



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ЫН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЭГҮЙ, “АЛСЫН ХАРАА 2050”-ИЙН ЗАРИМ
ЗОРИЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛООГҮЙ
БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ”

АУДИТЫН КОД: АГГ-2021/11-ШТА-ГА



Улаанбаатар хот
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Н.Анхбаяр

Утас: 262451 Цахим хаяг: ankhbayarn@audit.gov.mn

Ахлах аудитор М.Наранжаргал

Утас: 261456 Цахим хаяг: naranjargalm@audit.gov.mn

Аудитор А.Ариунзаяа

Утас: 262451 Цахим хаяг: ariunzayaa@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхтуяа

Утас: 261675 Цахим хаяг: munkhtuyab@audit.gov.mn

Аудитор Ц.Цолмон

Утас: 261456 Цахим хаяг: tsolmonts@audit.gov.mn

Аудитор Э.Уужимсан

Утас: 262451 Цахим хаяг: uujimsane@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Ц.Нямдорж/-т, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч /Я.Сарансүх/-д даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4-5
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ	6
ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ	6-7
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	7
ГАДААД ЭХ СУРВАЛЖИЙН ТОВЬЁГ	7
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	8

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	9-10
-------------------------	------

БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАГҮЙ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	11
---	----

- | | |
|--|-------|
| - Хөгжлийн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм сул, эрх зүйн орчны уялдаа хангалтгүй байна. | 11-12 |
| - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэжлийн институт тогтворгүй, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлээгүй, нэгдсэн тогтолцоо төлөвшөөгүй байна. | 12-14 |
| - Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан холбогдох байгууллага нь чиг үүргийн давхардалтай, хөндлөн болон босоо тогтолцооны уялдаа хангагдаагүй байна. | 14 |
| - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг үүсгэсэн боловч системийн үр нөлөө хангалтгүй байна. | 15-16 |
| - Төрийн байгууллагад хөгжлийн бодлого боловсруулах албан хаагчид тавигдах мэргэжлийн тусгай шаардлага, нарийвчилсан зохицуулалтгүй байна. | 16 |

БҮЛЭГ 2. “АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗАРИМ ЗОРИЛТ НЬ ТОДОРХОЙ, ХЭМЖИЖ БОЛОХУЙЦ, ХҮРЧ БОЛОХУЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ ШИНЖИЙГ БҮРЭН АГУУЛААГҮЙ БАЙНА	17
---	----

- | | |
|--|-------|
| - Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилгын 244 шалгуур үзүүлэлтээс Монгол Улсад 96 шалгуур үзүүлэлтийг тооцох нөхцөл бүрдээгүй байна. | 17-18 |
| - Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх хөгжлийн загвар тогтворгүй байна. | 18-20 |
| - Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг 2016-2020 оны хооронд үнэлж байсан ч үр дүн хангалтгүй байна. | 20 |
| - УИХ-аас Засгийн газарт Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах чиглэл өгсөн эсэх нь тодорхойгүй байна. | 21 |
| - “Алсын Хараа-2050” бодлогын баримт бичигт зарим зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулж батлаагүй нь зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна. | 22-23 |
| - “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн зарим зорилт нь тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц шинжийг бүрэн агуулаагүй байна. | 23-24 |

БҮЛЭГ 3. “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭЭГҮЙ, ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА	25
---	----

- | | |
|--|-------|
| - “МУТХҮБ-2030”-ийн үр дүнг илэрхийлсэн үзүүлэлтүүд I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүнг бүрэн хангаагүй байна. | 25-31 |
| - Макро эдийн засгийн бодлогын суурь зарчим бүрэн хангагдаагүй байна. | 32-35 |
| - “МУТХҮБ-2030”-ийн 4 бүлгийн 44 зорилтын I үе шатны 127 хүрэх түвшингээс 10.2 хувь нь үр дүнг хангасан, 42.5 хувь нь үр дүнг хангаагүй, 47.2 хувь хүрэх үр дүн тодорхойгүйгээс үр нөлөөг нь тооцох боломжгүй байна. | 36 |
| - Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 22 зорилтын 74 хүрэх түвшингээс үр дүнг хангасан 7, үр дүнг хангаагүй 31, хүрэх үр дүн тодорхойгүй 36 байна. | 36-42 |
| - Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 12 зорилтын 35 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 5, үр дүн хангагдаагүй 13, хүрэх үр дүн тодорхойгүй 17 байна. | 42-44 |

- Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 6 зорилтын 14 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 1, үр дүн хангагдаагүй 10, хүрэх үр дүн тодорхойгүй 3 байна.	44-47
- Тогтвортой хөгжлийн засаглалын зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлоогүйгээс бодлогын зорилт 2020 онд хүрэх үр дүнг хангасан эсэхийг хянах боломжгүй байна.	47-48
- МУТХҮБ-2030-ын баримт бичгийн I үе шатны зорилт, арга хэмжээний зардал, үр ашиг, үр нөлөөг тооцоогүй, санхүүжилтийг тайлагнаагүй байна.	48-49
- Үндэсний аудитын газраас 2018 онд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаас хойш үндэсний хэмжээний зорилтын биелэлтэд ахиц, дэвшил гараагүй байна.	49-50
ДҮГНЭЛТ	51
ЗӨВЛӨМЖ	52
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	53-57
ҮАГ-ЫН ТАЙЛБАР	58
ХАВСРАЛТ	59-61

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНДХХ	Ази, Номхон далайн Худалдааны хэлэлцээр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МУУХХБББ	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГД	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ОУС	Олон улсын стандарт
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ӨЗМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль

ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХБТТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улс тооцох боломжгүй дэлхийн ТХЗ-ын 96 шалгуур үзүүлэлтийн ангилал	18
Хүснэгт 2	“Алсын Хараа-2050”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр тооцоолсон төслийн тоо, төсөвт өртөг	22
Хүснэгт 3	“Алсын хараа-2050”-ийн үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн нэгтгэл	23
Хүснэгт 4	ДНБ-ий өсөлт, бууралт /хувиар/	26
Хүснэгт 5	Хүний хөгжлийн үзүүлэлт	26
Хүснэгт 6	Байгаль орчны багц үзүүлэлт	28
Хүснэгт 7	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдлын судалгаа	28
Хүснэгт 8	Ажиллагчдын сарын дундаж цалин /2014-2020 он/	28
Хүснэгт 9	Цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ	30
Хүснэгт 10	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	30
Хүснэгт 11	Нийт боловсруулах үйлдвэрлэлийн экспорт /Сая ам. Доллар/	31
Хүснэгт 12	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дээд хязгаар, тэнцвэржүүлсэн тэнцэлд ДНБ-ий эзлэх /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ хувийн үзүүлэлт	32
Хүснэгт 13	Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үзүүлэлтийн судалгаа	33
Хүснэгт 14	Гадаад валютын албан нөөцийн 2018-2020 оны 12 сарын /үлдэгдэл/ бүрдүүлэлтийн судалгаа	34
Хүснэгт 15	МУТХҮБ-2030-ын 4 зорилгын I үе шат (2016-2020)-д хүрсэн үр дүнгийн нэгтгэл	36
Хүснэгт 16	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, суурилагдсан хүчин чадлын 2016-2020 оны судалгаа	39
Хүснэгт 17	Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2016-2020 он тус бүрийн төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцвэржүүлсэн зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-ий эзлэх хувь, жил бүрийн бодит гүйцэтгэлийн судалгаа	41
Хүснэгт 18	2016-2020 он тус бүрийн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл,үүнээс гадаад өрийн хэмжээ, хуулиар тогтоосон хязгаар, ДНБ-ий эзлэх хувийн судалгаа	41
Хүснэгт 19	Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс	48
Хүснэгт 20	Үндэсний аудитын газраас 2018 онд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаас хойш үндэсний хэмжээний зорилтын биелэлтэд гарсан өөрчлөлтийн судалгаа	49

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ТХЗ-ын хэрэгжилтэд оролцогч байгууллагууд	9
Дүрслэл 2	МУТХҮБ-2030	10
Дүрслэл 3	Алсын Хараа-2050	10
Дүрслэл 4	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо	12
Дүрслэл 5	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем	15
Дүрслэл 6	Хүний нөөцийн судалгаа	16
Дүрслэл 7	МУТХҮБ-2030 болон дэлхийн ТХЗ-ын уялдаа	17
Дүрслэл 8	Алсын Хараа-2050-ийн шалгуур үзүүлэлтийн ангилал	18
Дүрслэл 9	Дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтийн судалгаагаар Монгол Улсын авсан оноо, эзэлсэн байр	18
Дүрслэл 10	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2016-2020 он/	19
Дүрслэл 11	Монгол болон Малайз Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	19
Дүрслэл 12	МУТХҮБ-2030-ийн зарчим, зорилт	25
Дүрслэл 13	МУТХҮБ-2030-ын зорилтот түвшин, 2016-2020 оны эдийн засгийн жилийн дундаж өсөлт	25
Дүрслэл 14	Нэг хүнд ногдох ҮНО-ийн зорилтот түвшин 17,500 ам.долларт харьцах гүйцэтгэлийн үзүүлэлт	26
Дүрслэл 15	Дундаж наслалт /2016-2020 он/	26
Дүрслэл 16	Ядуурлын түвшин /2014-2018 он/	27
Дүрслэл 17	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	27
Дүрслэл 18	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	27
Дүрслэл 19	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	28
Дүрслэл 20	1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин	29
Дүрслэл 21	100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	29
Дүрслэл 22	ЕБС-ийн анги дүүргэлт /улсын дундаж/	29

Дүрслэл 23	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо /мянган хүн/	30
Дүрслэл 24	Монгол Улсын цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрхийн судалгаа	31
Дүрслэл 25	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	31
Дүрслэл 26	Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшингийн үзүүлэлт	32
Дүрслэл 27	Засгийн газрын өрийн хуулиар тогтоосон дээд хязгаар, Засгийн газрын нийт өрийн 2016-2020 оны үлдэгдэл, ДНБ-д эзлэх хувь	32
Дүрслэл 28	Гадаад валютын албан нөөцийн 2014 оны 12 сараас 2020 оны 12 сарын хоорондох өөрчлөлтийн судалгаа	33
Дүрслэл 29	Инфляцын түвшин /2016-2020 он/	34
Дүрслэл 30	Жилийн инфляцад нөлөөлсөн бүрэлдэхүүн /2017-2020 он/	34
Дүрслэл 31	Гадаад валютын төгрөгтэй харьцах ханш /2014-2020 он/	35
Дүрслэл 32	Гахайн тоо толгой, Тахиан тоо толгой /2014-2020 он/	37
Дүрслэл 33	Хэрэглээний махны боловсруулалтад үйлдвэрлэлийн аргаар бэлтгэх хувь, хэрэглээний сүүний боловсруулалтад үйлдвэрлэлийн аргаар бэлтгэх хувь	38
Дүрслэл 34	Эрчим хүчний хэрэгцээний дотоодын эх үүсвэрийн үзүүлэлт /2016-2020 он/	39
Дүрслэл 35	Зүрх судасны өвчний шалтгаантай нас баралт	43
Дүрслэл 36	Хорт хавдраас үүдэлтэй нас баралтын үзүүлэлт	43
Дүрслэл 37	Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын үзүүлэлт	47
Дүрслэл 38	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тоо	47

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	МУТХҮБ-2030-ын хүрэх үр дүн тодорхойгүй зорилго, зарим зорилтын жагсаалт	53-55

Гадаад эх сурвалжийн товьёг

№	Эх сурвалжийн холбоос	Тайлбар
1	https://dashboards.sdgindex.org/profiles/mongolia	Дэлхийн ТХЗ-ийн хэрэгжилтийн үзүүлэлт
2	https://www.doingbusiness.org/en/rankings	Дэлхийн банкны Бизнес эрхлэлтийн үзүүлэлт
3	https://epi.yale.edu/downloads/epi2020report20210112.pdf	Йелийн их сургуулийн Байгаль орчний үзүүлэлтийн мэдээлэл
4	http://hdr.undp.org/en/data	Хүний хөгжлийн үзүүлэлтийн дата төв
5	https://www.transparency.org/en/	Транспарэнси Интернэшнл байгууллагын авлигын төсөөллийн индекс
6	https://www.oie.int/en/	Дэлхийн мал, амьтний эрүүл мэндийн байгууллага
7	https://www.moody's.com/	Зээлжих зэрэглэлийн үзүүлэлт (Мүүди)
8	https://www.fitchratings.com/	Зээлжих зэрэглэлийн үзүүлэлт (Фитч)

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, МҮЕА-ын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

“Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Үндэсний Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоо оновчтой байгаа эсэх;
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг хуульд заасан шаардлагын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг бүрэн үнэлж, дүгнэсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын урт хугацааны үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албад, холбогдох бусад байгууллагын баримт материалыг хамруулсан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ-с хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын ОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Н.Анхбаяр чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Наранжаргал, аудитор Ц.Цолмон, Б.Мөнхтуяа, А.Ариунзаяа, Э.Уужимсан нар 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:

Дэлхий нийтэд Ковид-19 өвчлөл цар тахлын хэмжээнд хүрч, Засгийн газраас тогтоосон хөл хорио, тодорхой хязгаарлалтын улмаас холбогдох яам, агентлаг дээр очиж ажиллах боломжгүй байдал үүсэж, баримт материалыг цахимаар авч, цахим мэдээллийн технологи нэвтрүүлэх бодлогын хүрээнд аудитыг цахимаар гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

УИХ-аас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /ХБТТХ/-ийг 2015 онд баталсан бөгөөд 4 дүгээр зүйлийн 4.1.12-т¹ "хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг хэлнэ” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг², Хорин тавдугаар зүйлийн 1.7³-д заасан үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-аас 2020 оны 5 дугаар сард Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль⁴ /ХБТТУТХ/-ийг шинэчлэн батлаж, ХБТТХ хүчингүй болсон байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулсан 70 дугаар чуулганаар Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт, 244 үзүүлэлтийг 2016 оноос 2030 оны хооронд 15 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд дэлхий нийтээр 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн байна.

Дүрслэл 1. ТХЗ-ын хэрэгжилтэд оролцогч олон талууд

Дэлхийн ТХЗ нь Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчин гэсэн үндсэн 3 тулгуурт суурилсан урт хугацааны, тогтвортой, дэлхий нийтийн хөгжлийн бодлогын баримт бичиг бөгөөд тогтвортой хөгжлийн зорилго нь “Leave no one behind” буюу **“Хэнийг ч орхигдуулахгүй байх”** гэсэн үндсэн уриатайгаар хэрэгжиж байна.

Дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад төрийн нэгдмэл бодлого зохицуулалттай байх арга хандлагыг баримтлах, олон талын оролцоог хангах шаардлага тулгарч байна.



Эх сурвалж: www.sdg.gov.mn

Монгол Улсын Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, үнэлэх харилцаанд оролцогч талуудын бүрэн эрх, чиг үүргийг ХБТТУТХ-аар зохицуулсан байна.

¹ 4.1.12: "хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичгийг.

² "... Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, ..."

³ "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна..."

⁴ 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан.

Дүрслэл 2. МУТХҮБ-2030

ХБТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна хэмээн тодорхойлсон бөгөөд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан байна.




Эх сурвалж: УАГ

Засгийн газар “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”/цаашид МУТХҮБ-2030 гэх/-ын I үе шат (2016-2020 он)-ны зорилтын үр дүн, зардал үр ашгийг нэгтгэж тайлагнаагүй, зорилтын үр нөлөөг үнэлээгүй байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050”-д тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.

Дүрслэл 3. Алсын Хараа-2050

ХБТТХ-ийн хүрээнд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” /цаашид “Алсын хараа-2050” гэх/ урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 9 зорилго, 47 зорилт, 73 шалгуур үзүүлэлтээр 3 үе шатанд /I үе шат 2021-2030 он, II үе шат 2031-2040 он, III үе шат 2041-2050 он/ хэрэгжүүлэхээр баталсан байна.



Эх сурвалж: УАГ

БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАГҮЙ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, Хорин тавдугаар зүйлийн 1.7-д “...**Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна...**” гэж заасан байна.

1.2. Монгол Улсын Үндсэн хуулийн⁵ зургадугаар зүйлийн 2-т “...**Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, ...**”, Хорин тавдугаар зүйлийн 1.7-д “**төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна...**” гэж заасан үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)⁶-ийг шинэчлэн баталсан байна. Тухайлбал:

- ХБТТУХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилтыг “...хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх” гэж тодорхойлон, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар салбар дундын шууд удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий бие даасан яамтай байхаар тусгасан боловч тус хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр⁷ төрийн захиргааны байгууллага болгон өөрчилсөн нь хуулийн зорилт, үзэл баримтлалд нийцээгүй байна.
- Уг хуулийн өөрчлөлтийн улмаас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институтын нэгдсэн тогтолцоо оновчтой бүрдэж, салбарууд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангагдаж чадахгүй, хууль үр дүнтэй хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм сул, эрх зүйн орчны уялдаа хангалтгүй байна

1.3. ХБТТУХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.15-д “оролцогчдын хариуцлагын зарчим”-ыг анх удаа тодорхойлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчид нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харилцаан дахь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг заасан байна. Үүнд:

- Тус хуулийн 9.2.7-д УИХ-аас Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, үр дүнгээс хамаарч холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг Ерөнхий сайдад хүргүүлэх, 9.2.8-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн гүйцэтгэлийн үр дүнгээс хамаарч Засгийн газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг гаргахар заасан нь ач холбогдолтой зохицуулалт болжээ.

1.4. ХБТТУХ-ийг батлахдаа Төсвийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулаагүйгээс дээрх хуулиудын зарим заалтууд хоорондоо нийцэхгүй, хууль, эрх зүйн орчны уялдаа хангалтгүй байна. Тухайлбал:

- ХБТТУХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.5-д “Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан ч Зөрчлийн тухай хуульд тусгайлсан зохицуулалтыг тусгаагүй байна;
- ХБТТУХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг”, 6 дугаар зүйлийн 6.9-т “Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна” гэж заасан ч Төсвийн тухай

⁵ Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр

⁶ 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

⁷ 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар

хуулийн 9.1.2, 10.3, 10.1.3, 71.2-т “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэсэн зохицуулалттай байгаа нь нэршлийн хувьд зөрчилдөж;


- ХБТТУТХ-ийн 4.1.10-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичиг” гэж заасан байхад Төсвийн тухай хуулийн 28.8-д “Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно” гэсэн зохицуулалттай.

1.5. Монгол Улсад хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчинд ихээхэн ахиц дэвшил гарсан хэдий ч дунд болон урт хугацааны бодлого зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийх, үнэлгээний тайланг хариуцсан яам, агентлаг нь өөрсдөө гаргаж байгаагаас хэрэгжилтийг хангуулах нэгдсэн зохицуулалт сул, үр дүнгийн хяналтын механизм, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэргэжлийн институт тогтворгүй, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлээгүй, нэгдсэн тогтолцоо төлөвшөөгүй байна

1.6. Монгол Улсын Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, үнэлэх харилцаанд оролцогч талуудын бүрэн эрх, чиг үүргийг ХБТТУТХ-аар зохицуулсан бөгөөд институтийн тогтолцоо дараах байдалтай байна.

Дүрслэл 4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо



Эх сурвалж: УАГ

1.7. УИХ-аас Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах талаар Засгийн газарт чиглэл өгч /УИХ-ын ЭЗБХ-ны дэргэдэх Тогтвортой хөгжлийн дэд хороо ажилладаг/, Засгийн газрын өргөн мэдүүлсэн хөгжлийн нэгдсэн бодлогын баримт бичгийн төслийг баталдаг.

Олон улсын туршлага:

Шри-Ланка улс дэлхийн ТХЗ 2030-ын хэрэгжилт, хяналтыг хэрэгжүүлэх хэд хэдэн санаачилга гаргасны нэг нь ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд улс төрийн манлайллаар хангах зорилгоор Парламентын Тогтвортой хөгжлийн Сонгон шалгаруулалтын хороо /Parliamentary Select Committee /-г байгуулсан байна. Тус хороо нь холбогдох салбарын яамдтай зөвшилцөн үндэсний бодлого, хууль тогтоомжийг боловсруулах; дотоодын нөөцийг хуваарилах, олон улсын санхүүжилтийн эх үүсвэрийг олох; Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хоорондын зохицуулалтыг хийх; төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих; НҮБ-ын агентлагууд болон иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэгийг авах; бүс нутгийн болон олон улсын түвшинд улс орнуудын хооронд туршлагыг судлах, өөрийн орны туршлагыг хуваалцах; тусдаа мэдээллийн сан боловсруулж, ахиц дэвшлийг тогтмол хянах чиг үүрэгтэй байна.

1.8. Засгийн газар нь УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын хөгжлийн нэгдсэн бодлогын баримт бичгийн төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн оролцоог ханган боловсруулж, хөгжлийн нэгдсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, 4 жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийсэн тайланг УИХ-д танилцуулах үүрэгтэй байна.

1.9. Засгийн газрын дэргэд Тогтвортой хөгжлийн үндэсний хороо ажиллаж, Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтаар⁸ “Тогтвортой хөгжлийн үндэсний хороо”-ны бүрэлдэхүүнийг баталж, 2015 оны 475, 2017 оны 27, 2021 оны 10 дугаар тогтоолоор уг бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулжээ.

1.10. “Тогтвортой хөгжлийн үндэсний хороо”-ны ажиллах журмыг Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 99 дүгээр тогтоолоор баталсан. Үүнээс өмнө тус хороо үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм журамгүй ч 2018 онд 1 удаа, 2021 онд 1 удаа тус тус хуралдсан байна⁹.

1.11. Засгийн газрын 1999 оны 138 дугаар тогтоолоор Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах, биелэлтийг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилготой Шинжлэх ухааны академийн харьяанд Үндэсний хөгжлийн хүрээлэнг анх байгуулж, Засгийн газрын 2006 оны 62 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны академийн харьяанд байхаар тогтоожээ.

1.12. Засгийн газрын 2015 оны 27, 501, 2019 оны 328 дугаар тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн харьяа Стратеги судалгааны хүрээлэн¹⁰-д нэгтгэсэн ч Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах, биелэлтийг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

1.13. ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.12.1-9.12.8-д заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлэх Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулагдаагүй, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, норм, норматив, стандартыг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх мэргэжлийн институт байхгүй байна. Үүнд:

- Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх;
- эдийн засгийн хөгжлийн суурь дэвсгэр болох хүн ам, хөдөлмөрийн нөөц, эдийн засгийн эргэлтэд оруулах малын гаралтай түүхий эд, ус, газрын баялгийн нөөцийн судалгааг байршлаар нарийвчлан хийж, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн төсөөлөл, нөөцийг ашиглах оновчтой арга замыг тодорхойлох;
- салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай норм, норматив, стандартыг боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи, багаж хэрэгсэл ашиглах, судалгаа шинжилгээний хамтарсан арга хэмжээ зохион байгуулах;
- үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, шинэчлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

⁸ Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн тогтоол “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай”-ын 17 дугаар хавсралтаар “Тогтвортой хөгжлийн үндэсний хороо”-ний дарга МУ-ын Ерөнхий сайд, дэд дарга Сангийн сайд, нарийн бичгийн дарга Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, гишүүд УИХ-ын ЭЗБХ-даргын зөвшилцсөнөөр, ТБХ-ны даргын, БОХХААБХ-ны даргын зөвшилцсөнөөр, Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга, БОНХАЖС, ГХС, ХЗС байна.

⁹ Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор байгуулагдсан Тогтвортой хөгжлийн үндэсний хороо 2018 онд 5 дугаар сарын 30-нд анх хуралдсан байна.

¹⁰ Стратеги судалгааны хүрээлэн нь Дэлхий нийтийн болон бүс нутгийн улс хоорондын харилцаа, аюулгүй байдлын хамтын ажиллагааны асуудал, үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй эерэг, сөрөг хүчин зүйлсийг цогцоор судлан дүн шинжилгээ хийх, төрийн бодлогын стратегийн чиглэлийн үндсийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл, санал, зөвлөмжөөр хангах чиг үүрэгтэй.

1.14. ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.12-т “Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаа, боловсруулалтын ажилд шаардагдах хөрөнгө, тоног төхөөрөмж, санхүү, боловсон хүчний нөөцөөр хангах” гэж ҮХГ-ын чиг үүрэгт заасан ч одоогоор Үндэсний хөгжлийн хүрээлэнг байгуулаагүй байна.

1.15. Монгол Улсын Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт түүний хэрэгжилтэд оролцогч ЗГХЭГ, Сангийн яам, ҮХГ-ын “Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2016 оны 91, 119, 2020 оны 41, 132, 2021 оны 56 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2016 оны 64 дүгээр захирамж, ЗГХЭГ-ын 2021 оны 23 дугаар тушаалаар тус тус баталсан байна.

1.16. УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлагаар “Үндэсний хөгжлийн газар”¹¹-ыг 55 орон тоотой, 5 хэлтэстэй баталсан, 2018 онд¹² 5 газар, 1 хэлтэстэй, 2020 онд¹³ 6 хэлтэс, 1 албатай болгож өөрчлөхдөө статусыг нь бууруулсан байна.

1.17. Засгийн газрын тохируулагч агентлаг ҮХГ нь ХБТТХ, ХБТТУТХ-аар болон байгууллагын үйл ажиллагааны стратеги хөтөлбөрт тусгасан “хөгжлийн бодлого төлөвлөх боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт тавих” чиг үүргээ хэрэгжүүлэхэд статусын хувьд холбогдох төрийн байгууллагуудтай шууд харьцахад хүндрэлтэй, дээд шатны байгууллагаар дамжуулан баримт материал, мэдээлэл судалгаа гаргахад цаг хугацаа алдагдаж, шийдвэр гаргалт удаашралтай зэрэг асуудал тулгарч байжээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан холбогдох байгууллага нь чиг үүргийн давхардалтай, хэвтээ болон босоо тогтолцооны уялдаа хангагдаагүй байна

1.18. ХБТТУТХ болон Засгийн газрын тухай хуулиар “Макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт”-ыг Сангийн яам, ҮХГ-ын чиг үүрэгт дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:

- ХБТТУТХ-аар “Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх” гэж заасан.

Сангийн сайдын чиг үүрэг:

- Засгийн газрын тухай хуулиар Сангийн сайдын эрхлэх асуудал чиг үүрэгт уг хуулийн 5¹⁴ дахь хэсгийн 6-т “Макро эдийн засгийн бодлого төлөвлөлт, зохицуулалт” асуудал хариуцахаар заасан байна.

1.19. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн асуудал давхардаж байгаа нь төрийн захиргааны байгууллагуудын харилцан мэдээ, мэдээлэл солилцоход хүндрэл үүсэх, макро эдийн засгийн бодлого төлөвлөлт, зохицуулалт уялдаагүй байх, босоо тогтолцоо хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

¹¹ МУЕС-ын 2016 оны 8-р сарын 12-ны өдрийн 38 дугаар захирамжаар ҮХГ-ын зохион байгуулалтын бүтцийг баталсан.

¹² МУЕС-ын 2018 оны 11-р сарын 29-ний өдрийн 192 дугаар захирамжаар ҮХГ-ын зохион байгуулалтын бүтцийг баталсан.

¹³ ЗГХЭГ-ын даргын 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн 99 дүгээр тушаалаар ҮХГ-ын зохион байгуулалтын бүтцийг баталсан.


¹⁴ Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн “Засгийн газрын бүрэлдэхүүн” 5 дахь “Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ”.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг үүсгэсэн боловч системийн үр нөлөө хангалтгүй байна

1.20. ХБТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.3¹⁵, 22.4¹⁶, ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.9¹⁷, 9.4.10¹⁸ болон 22 дугаар зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтлөх, холбогдох журмыг батлах чиг үүргийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хариуцуулсан байна.

Дүрслэл 5. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем

1.21. АХБ-аас ХБТТХ-ийн хэрэгжилтийг хангах, бүх түвшний бодлого боловсруулагчдад дэмжлэг үзүүлэх, иргэд, олон нийт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглах зорилгоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл”-ийг ҮХГ-тай хамтран хэрэгжүүлж, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг боловсруулсан байна.



Эх сурвалж: <https://development.gov.mn/home>

1.22. Тус мэдээллийн системд 2019 онд хүчин төгөлдөр мөрдөж буй урт болон дунд хугацааны 203 бодлогын баримт бичиг¹⁹-ээс 2021 оны 12 дугаар сарын байдлаар 22 бодлогын баримт бичиг буюу 10.8 хувийг байршуулсан байна.

1.23. ҮХГ “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй, хүний нөөц хангалтгүй, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, шинэчлэх ажил удаашралтай, мэдээллийн нэгдсэн сангийн үр нөлөө хангалтгүй байна.

1.24. Мөн төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд мэдээллийн нэгдсэн санг хариуцсан мэргэжилтэнгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй нь ХБТТУТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.4²⁰ дэх, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмын 3.5²¹ дахь заалт тус тус хэрэгжээгүй байна.

1.25. ХБТТУТХ 2020 онд шинэчлэгдсэнтэй уялдаж “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”²², “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал”²³, “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”²⁴ тус тус батлагдсан. Иймээс Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, хөгжүүлэх шаардлагатай байна.

¹⁵ Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө

¹⁶ Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална

¹⁷ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журам батлах

¹⁸ мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх

¹⁹ Үндэсний хөгжлийн газар. (2019). Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаанд хийсэн үнэлгээний ажлын тайлан

²⁰ Холбогдох байгууллага, албан тушаалтан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

²¹ “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэнтэй байна”

²² Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан

²³ Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан

²⁴ ҮХГ-ын даргын 2021 оны А-41 дүгээр тушаалаар батлагдсан


1.26. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах журам”²⁵-аар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулахтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан ч хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна.

Төрийн байгууллагад хөгжлийн бодлого боловсруулах албан хаагчид тавигдах мэргэжлийн тусгай шаардлага, нарийвчилсан зохицуулалтгүй байна

1.27. БОАЖЯ, УУХҮЯ, ХНХЯ чиглэсэн бодлого, төлөвлөлтийн нэгжтэй, бусад яамд болон ҮХГ нь нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан газартай байна.

Дүрслэл 6. Хүний нөөцийн судалгаа

1.28. Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөх, боловсруулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгжийн тухайн албан тушаалд тогтвортой ажилласан байдлыг судалж үзэхэд яамдын Бодлого, төлөвлөлт болон ХҮШДАГ-т 2016-2020 оны хооронд нийт 332 албан хаагч ажиллаж байснаас 1 жил хүртэл 35.2 хувь, 2 жил 14.5 хувь, 3 жил 13.6 хувь, 4 жил 7.8 хувь, 5 ба түүнээс жил ажилласан 28.9 хувийг тус тус эзэлж байна.



Эх сурвалж: ҮАГ

1.29. ТАЗ-өөс 2014, 2017 онд Монгол Улсын төрийн захиргааны албан тушаалын индексийг шинэчлэн баталсан бөгөөд хөгжлийн болон салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр мэргэжлийн индекс бүртгэгдээгүй байна.

1.30. ХЗДХЯ нь хөгжлийн бодлогыг төлөвлөх асуудлыг хариуцсан нэгжгүй, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар батлагдсан бодлогын хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа нь салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт орхигдох магадлалтай байна.

²⁵ ҮХГ-ын даргын 2019 оны А-158 дугаар тушаалаар батлагдсан

БҮЛЭГ 2. “АЛСЫН ХАРАА 2050” БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗАРИМ ЗОРИЛТ НЬ ТОДОРХОЙ, ХЭМЖИЖ БОЛОХУЙЦ, ХҮРЧ БОЛОХУЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ ШИНЖИЙГ БҮРЭН АГУУЛААГҮЙ БАЙНА

2.1. Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлтийг 2016-2030 оны хооронд 15 жилийн хугацаанд 193 орон 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхдээ үндэсний онцлогт нийцүүлсэн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Гүрж улс ойрын 5-7 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго 169 зорилтоос 13 зорилго 79 зорилтыг тодорхойлж тэргүүлэх ач холбогдол өгчээ. Мөн 40 зорилтыг орон нутгийн түвшинд нутагшуулж, үндэсний хэмжээнд 5 зорилтыг шинээр тодорхойлсон байна.
- Вьетнам улс дэлхийн ТХЗ-оос 115 зорилтыг эрэмбэлэн, ахиц дэвшилд хяналт тавих 158 шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.
- Энэтхэг улс 16 зорилтын хүрээнд 62 шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэж, зорилтот түвшнийг тодорхойлсон байна.

2.2. Хөгжиж байгаа улс орнуудын хөгжлийн бодлого нь эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, ялангуяа ажилгүйдэл, ядуурал, дундаж давхаргын хүрээг тэлэх, эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгоход чиглэсэн бол хөгжингүй улс орнуудын хувьд дэлхийн тогтвортой хөгжлийн зорилттой илүү нийцсэн, байгаль орчин, экологи, хүний хөгжил, боловсролд түлхүү хандсан урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, бодлого баримталдаг байна²⁶.

Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилгын 244 шалгуур үзүүлэлтээс Монгол Улсад 96 шалгуур үзүүлэлтийг тооцох нөхцөл бүрдээгүй байна

Дүрслэл 7. МУТХУБ-2030 болон дэлхийн ТХЗ-ын уялдаа

2.3. Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилгоос “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д 7 зорилго шууд уялдсан, 9 зорилго агуулгын хувьд тусгагдсан, харин Далай тэнгисийн нөөцийг хамгаалах 1 зорилго хамааралгүй байна.

2.4. “Алсын Хараа-2050” МУУХХБББ-ийн 9 зорилго, 47 зорилтыг Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго 169 зорилттой уялдуулсан эсэхэд Засгийн газраас судалгаа хийж уялдаатай 117, агуулгаараа уялдаатай 23, уялдаагүй 10, хамааралгүй 14, хэрэгжсэн 5 зорилт байна гэж дүгнэсэн ч судалгааны ямар арга аргачлалыг ашиглаж үнэлсэн нь тодорхойгүй байна.



Эх сурвалж: <https://sdg.1212.mn/>

- Олон Улсын туршлагаас харахад: Шри-Ланк Улс нь Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтыг үндэсний хэмжээний зорилго зорилттой уялдаа уялдааг Нэгдмэл түргэвчилсэн үнэлгээ (RIA)²⁷-ний аргачлалаар НҮБХХ-тэй хамтран үнэлсэн бөгөөд дэлхийн тогтвортой хөгжлийн 169 зорилтоос 16 нь хамааралгүй, 44 нь тусгаагдаагүй, үлдсэн хэсэг нь бүрэн тусгагдсан байна хэмээн дүгнэсэн байна.

²⁶ Монгол Улсын Засгийн газар, Алсын Хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /Төслийн эхний хувилбар/, х.22

²⁷ Дэлхийн ТХЗ-г тухайн орны үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигтэй хэрэгн уялдаж байгааг үнэлэхийн тулд RIA арга аргачлалыг ашигладаг бөгөөд үндсэн 4 арга аргачлалыг ашигладаг байна. Нэгдүгээр үе шатанд үндэсний зорилго зорилтыг хэрхэн төлөвлөж, зураглалаа гаргасан талаар, хоёрдугаар үе шатанд үндсэн 3 хэмжүүр буюу Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг 5P төрөлд тэнцвэртэй байдлаар тусгагдсан талаар гэх мэтчилэн үнэлдэг байна.

Хүснэгт 1. Монгол Улс тооцох боломжгүй дэлхийн ТХЗ-ын 96 шалгуур үзүүлэлтийн ангилал

2.5. Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилгын 244 шалгуур үзүүлэлтээс Монгол Улсад 6 үзүүлэлт судлагдаж байгаа, 96 үзүүлэлтийг тооцох боломжгүй байна.

96 шалгуур үзүүлэлтийн ангилал	
Мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй	55
Мэдээллийн эх үүсвэр хангалтгүй	24
ОУ-ын байгууллагаас мэдээллийг тооцдог	9
Арга зүй, тооцооллыг тодорхой болгох шаардлагатай	8
Нийт	96

Эх сурвалж: УАГ

2.6. МУЕС-ын 2019 оны 2 дугаар захирамжийн дагуу 8 дэд ажлын хэсэг ТХЗ-ыг үндэслэн “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, 225 шалгуур үзүүлэлт”-ийн төслийг²⁸ боловсруулан 2020 оны 02 дугаар сард²⁹ ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Засгийн газраас УИХ-д Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг 2021 оны 12 дугаар сарын байдлаар өргөн бариагүй, Дэлхийн ТХЗ-ыг 2030 онд үнэлүүлэхэд бэлэн биш байна.

2.7. УИХ-аас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 73 шалгуур үзүүлэлтийг баталсан бөгөөд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний шалгуур үзүүлэлтийн төсөлтэй уялдсан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 8. “Алсын Хараа-2050”-ийн шалгуур үзүүлэлтийн ангилал


2.8. “Алсын хараа 2050”-ын 9 зорилго, 47 зорилтын хяналт-шинжилгээ, үнэлгээний 73 шалгуур үзүүлэлтээс 52 буюу 71 хувь нь үндэсний онцлогт нийцсэн, 21 буюу 29 хувь нь дэлхийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтэд тус тус нийцсэн байна.



Эх сурвалж: УАГ

Дүрслэл 9. Дэлхийн ТХЗ-ийн хэрэгжилтийн судалгаагаар Монгол Улсын авсан оноо, эзэлсэн байр

2.9. Дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтэд хамрагдах 193 орноос 165³⁰ орныг хамруулсан судалгааны³¹ үр дүнгээр Монгол Улсыг 92 үзүүлэлтээр үнэлэхэд 2021 оны байдлаар 63.8 оноо³² авч 106 дугаар байранд³³ орсон байна.



Эх сурвалж: <https://dashboards.sdindex.org/profiles/mongolia>

Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх хөгжлийн загвар тогтворгүй байна

2.10. ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь ...**хөгжлийн загварт** суурилсан байна” гэж заасан хэдий ч хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам³⁴-д “**хөгжлийн загвар**” гэсэн нэр томъёог нарийвчлан тодорхойлоогүй байна.

2.11. Засгийн газраас УИХ-д өргөн барьсан “Алсын хараа-2050”-ын төсөлд “...Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого нь үндэсний давтагдашгүй онцлогт

²⁸ Ажлын хэсэг 2019 оны 3 дугаар сараас 2019 оны 9 дүгээр сарын хооронд 6 сарын хугацаанд боловсруулж

²⁹ УХГ-ын 2020 оны 2 дугаар сарын 01/446 дугаартай албан бичгээр Засгийн газарт хүргүүлсэн

³⁰ 193 орноос тус үнэлгээнд хамрагдсан 165 орон, мэдээлэл гарах боломжгүй 28 орон байна.

³¹ Кембрижийн их сургуулийн судалгааны багаас хийсэн судалгаа

³² ТХЗ Оноо: Тус оноо нь тухайн улсын 17 ТХЗ-д хүрэх нийт ахиц дэвшлийг хэмждэг. Оноог ТХЗ-ын биелэлтийн хувь гэж ойлгох бөгөөд 100 оноо нь бүх ТХЗ-д хүрснийг илтгэнэ.


³³ ТХЗ Индекс: ТХЗ-ийн Оноонд үндэслэн Улс Орнуудыг эрэмбэлсэн байдал.

³⁴ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан.

суурилсан, дэлхийн дэвшилтэт үзэл санаатай хослуулсан Монгол Улсын хөгжлийн загвар...” гэж тодорхойлжээ.

2.12. Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх 2016 он болон 2020 оны бодлогын баримт бичигт хөгжлийг дараах байдлаар тодорхойлсон ч 4 жилийн хугацаанд өөрчлөгдөж байгаа нь хөгжлийн загвар тогтворгүй байна.

Дүрслэл 10. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2016-2020 он/



Эх сурвалж: УИХ-ын 2016 оны 19, 2020 оны 52 дугаар тогтоол

2.13. Үндэсний онцлогт тохирсон урт хугацааны хөгжлийн бодлогыг Монгол Улс, Малайз Улс 30 жилээр тодорхойлсон бөгөөд 2 улсын хэтийн бодлого зорилгыг харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 11 Монгол болон Малайз Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Монгол Улс	
• Урт хугацааны хөгжлийн бодлого: “Алсын Хараа-2050” Хэрэгжих хугацаа: 30 жил Хэтийн зорилго: Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудыг нэг болох Бодлогын зорилго: Үндэсний нэгдмэл үнэт зүйл - Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно. Хүний хөгжил - Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. Амьдралын чанар ба дундаж давхарга- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ. Эдийн засаг- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно. Засаглал- Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, ёсны хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно. Ногоон хөгжил- Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна. Амар тайван, аюулгүй нийгэм- Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана. Бүс, орон нутгийн хөгжил- Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ. Улаанбаатар ба дагуул хот- Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.	

Малайз Улс



- **Урт хугацааны хөгжлийн бодлого:** “2020 он хүртэлх хөгжлийн Алсын Хараа”,
- **Хэрэгжих хугацаа:** 30 жил
- **Хэтийн зорилго:** Малайз Улсыг эдийн засаг, улс төр, нийгэм, оюун санаа, сэтгэл зүй, соёлын хувьд шинэчлэн хөгжүүлэх
- **Бодлогын зорилт:**
 - Малайзыг нэгдмэл үндэстэн болж төлөвшүүлэх
 - Сэтгэл санааны хувьд чөлөөтэй, аюулгүй, хөгжсөн Малайзын нийгмийг бий болгох
 - Боловсронгүй, төлөвшсөн ардчилсан нийгмийг дэмжин, бүтээн байгуулах
 - Ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг бүрэн төлөвшүүлсэн нийгмийг бий болгох
 - Төлөвшсөн, либерал, хүлээцтэй буюу харилцан хүндэтгэлтэй нийгмийг бий болгох
 - Шинжлэх ухаанч, дэвшилтэт нийгмийг бий болгох
 - Бүх талын халамж анхаарал тавьдаг нийгэм байгуулах
 - Эдийн засгийн хувьд шударга нийгмийг баталгаажуулах
 - Хөгжиж цэцэглэсэн нийгмийг байгуулах

Эх сурвалж: УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол, Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгах судалгааны тайлан

2.14. Улс орны хөгжлийн бодлого нь өмнөх үеийн түүхэн сургамж, зан заншилд тулгуурлан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго, зорилтуудыг оновчтой тогтоон, ойрын ирээдүйд ард иргэдийн сайн сайхан амьдралыг бий болгон баталгаажуулахад чиглэдэг байна.

Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг 2016-2020 оны хооронд үнэлж байсан ч үр дүн хангалтгүй байна

2.15. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “МУТХҮБ-2030” бодлогын баримт бичгийг баталж, УИХ болон Засгийн газраас баталсан хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг ХБТТХ, түүний үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах үүргийг Засгийн газарт өгсөн³⁵ байна.

2.16. УИХ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг” нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг /2016 онд 170³⁶, 2019 онд 168, 2020 онд 513/ үнэлэхэд нэршил (үзэл баримтлал, бодлого, бодлогын үндэс, стратеги, үндэсний болон дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө) болон хэрэгжүүлэх хугацаа нь зөрүүтэй, бодлогын зорилтууд нь хоорондоо уялдаагүй, шалгуур үзүүлэлтгүй, санхүүгийн эх үүсвэргүй, хэрэгжих хугацаа нь дууссан, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, хууль зүйн үндэслэл нь хүчингүй болсон зэрэг баримт бичиг байгааг үнэлж тайлагнасан ч үр дүн хангалтгүй байна. Тухайлбал:

- УХГ нь 2016 онд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн 170 баримт бичгийг үнэлж³⁷, үр дүнг Ерөнхий сайдад тайлагнасан байна.
- УХГ-аас 2019 онд 168 бодлогын баримт бичгийн үнэлгээний дүнг нэгтгэн 2019 онд ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.
- УХГ-аас 2020 онд 513 бодлогын баримт бичгээс 392 бодлогын баримт бичгийг хүчингүй болгуулах саналаа ЗГХЭГ-т хүргүүлсэнээс Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор 62 бодлогын баримт бичгийг, УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор 17 бодлогын баримт бичгийг тус тус хүчингүй болгосон байна³⁸.

³⁵ Уг тогтоолын 2.2 дахь заалт УИХ болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах”

³⁶ УХГ-ын тухайн үеийн үнэлгээ хийх шаардлагатай бодлогын баримт бичгийн судалгаагаар УИХ-ын тогтоолоор 55, Засгийн газрын тогтоолоор 115 бодлогын баримт бичиг батлагдсан байжээ.

³⁷ Тухайн үед хөгжлийн бодлогын баримт бичгийг үнэлэх нэдсэн аргачлалгүй байснаас НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр бодлогын баримт бичигт үнэлгээ хийх, бодлогын зорилтыг уялдуулан боловсруулах аргачлалыг боловсруулж, УХГ-ын 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 29 дүгээр тушаалаар “Бодлогын баримт бичгийн уялдааг үнэлэх заавар”-ыг баталсан байна.

³⁸ 313 бодлогын баримт бичиг хүчингүй болгоогүй хэвээр байна.

УИХ-аас Засгийн газарт Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах чиглэл өгсөн эсэх нь тодорхойгүй байна

2.17. ХБТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна” гэж заасан боловч “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг³⁹ хэрэгжүүлэх хугацааг 30 жилээр тогтоосон байна.

2.18. ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах талаар Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу удирдамж гаргаж, төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна” гэж заасан бөгөөд УИХ-аас Засгийн газарт Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах чиглэл өгсөн эсэх нь тодорхойгүй байхад Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамж, ЗГХЭГ-ын 2019 оны 65 дугаар тушаалаар “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (I таван жилийн) боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан байна.

2.19. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамжаар “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (I таван жилийн) боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 65 дугаар тушаалаар “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого (2020-2045 он)-ын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх Дунд хугацааны төлөвлөгөө (2020-2025 он)”-ний төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий 8 ажлын дэд хэсэг /Арга зүй, нэгтгэл, Үндэсний үнэт зүйл, Хүн ба нийгэм, Эдийн засаг, Байгаль орчин, Үндэсний аюулгүй байдал, Засаглал, Олон нийтэд таниулж санал, зөвлөмж гаргах/ хамтран “Алсын Хараа-2050” баримт бичгийн төслийг боловсруулсан байна.

2.20. Харин “Алсын Хараа-2050”-ын “Бүсчилсэн хөгжил” бүлгийг ҮХГ-аас ХБТТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.2⁴⁰, 13.5⁴¹-д заасан чиг үүргийн хүрээнд боловсруулсан байна.

2.21. Мөн “Алсын хараа 2050”-ын “Улаанбаатар ба дагуул хот” бүлгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх явцад иргэд, олон нийтээс гарсан Улаанбаатар хотын хөгжлийн асуудлыг тусад нь авч үзэх саналд үндэслэн НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/1146 дугаар захирамж, НЗДТГД-ын А/160 тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулсан байна.

2.22. МУТХҮБ-2030 бодлогын баримт бичгийн II, III үе шатанд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаас “Алсын хараа-2050”-д 27 хувь нь шууд, 73 хувь нь агуулгаараа туссан, үр дүнг илэрхийлэх үндсэн 20 үзүүлэлтээс 70 хувь нь шууд, 30 хувь нь агуулгаараа тусч уялдсан байна.

2.23. Засгийн газраас өргөн барьсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг Монголын үндэсний олон нийтийн телевиз болон хөдөө, орон нутагт зохион байгуулсан байна.

³⁹ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулагдан батлагдах үед Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан. Харин Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль нь УИХ-ын 2020 оны анхдугаар чуулган 2020.06.30-ны өдөр эхэлсэн өдрөөс хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

⁴⁰ Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

⁴¹ Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

“Алсын Хараа-2050”-ын зарим зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулж батлаагүй нь зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна

2.24. Засгийн газраас УИХ-д өргөн барьсан “Алсын Хараа-2050” бодлогын баримт бичгийн төсөлд 9 зорилгын 50 зорилтод хамаарах нийт 138 шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж, суурь түвшин, хүрэх түвшин, үр дүнг гурван 10 жил тус бүрээр тоон үзүүлэлтээр илэрхийлж боловсруулсан байна.

2.25. Гэтэл УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050”-ын 73 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшингийн тоон үзүүлэлтийг эхний 10 жилд (2025 он, 2030 он) тооцсон, хоёр дахь 10 жил буюу 2040 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй, харин гурав дахь 10 жил буюу 2050 оны хүрэх түвшинг тооцож баталсан байна.

2.26. “Алсын хараа 2050”-ын төсөлд эдийн засгийн болон бүсчилсэн хөгжлийн зорилгын 5 зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулаагүй нь Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 54.1⁴² дэх заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

Эдийн засгийн зорилго:

- Зорилт 4.3. Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.
- Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөөчилнө.
- Зорилт 4.5. Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Зорилт 4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.

Бүсчилсэн хөгжлийн зорилго:

- Зорилт 8.6. Улаанбаатар хот, Төвийн бүсэд бий болсон хүн ам, нийгэм, эдийн засгийн төвлөрлийг төлөвлөлттэйгөөр задлах, төв, дагуул хотуудын зохистой бүтцийг бүрдүүлж, мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай бүс нутаг болгон хөгжүүлнэ.

Хүснэгт 2. “Алсын Хараа-2050”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр тооцоолсон төслийн тоо, төсөвт өртөг

2.27. Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсөлд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилгын хүрээнд нийт 186 төсөл⁴³ хэрэгжүүлэхэд 145,102.6 тэрбум төгрөгийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн хөрөнгө шаардлагатай гэж тооцоолсон байна.

№	Зорилго	төслийн тоо	Төсөвт өртөг, /тэрбум төг/
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	11	708.3
2	Хүний хөгжил	23	16,356.8
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	1,685.5
4	Эдийн засаг	33	54,501.5
5	Сайн засаглал	6	70.9
6	Ногоон хөгжил	17	13,659.1
7	Амар тайван, аюулгүй нийгэм	22	2,121.2
8	Бүсчилсэн хөгжил	56	48,166.8
9	Улаанбаатар ба дагуул хот	12	7,832.5
Нийт дүн		186	145,102.6

Эх сурвалж: “Алсын Хараа-2050” төслийн хувилбар, ЗГХЭГ

2.28. Гэвч УИХ-аас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт хүний нөөц, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, түүний эх үүсвэрийг батлаагүй байна.

2.29. Засгийн газраас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр УИХ-д өргөн барьсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд 138 шалгуур үзүүлэлт, 983 үйл ажиллагаа, 513 хүрэх үр дүнг тусгаснаас УИХ-ын хэлэлцүүлгийн

⁴² “бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна”

⁴³ 186 төсөл, хөтөлбөрийн судалгаанд ТАХ-ний бэлтгэл хангагдаагүй, мэдээлэл, судалгаагүй, ТЭЗҮ-гүй, ТЭЗҮ-тэй, судалгаа хийгдсэн, схем зурагтай, зураг төсөлтэй зэрэг жагсаалт байна.

явцад шинээр 11 шалгуур үзүүлэлт, 97 үйл ажиллагаа, 65 хүрэх үр дүнг нэмж баталсан байна.

Хүснэгт 3. “Алсын хараа-2050”-ийн үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн нэгтгэл

Зорилгын нэр	Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсөл			УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан			УИХ-ын хэлэлцүүлгийн явцад хасагдаж, нэмэгдсэн					
	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа		Шалгуур үзүүлэлт		Хүрэх үр дүн	
							+	-	+	-	+	-
Үндэсний нэгдмэл үнэт зүйл	66	4	47	64	3	47	4	6	1	2	0	0
Хүний хөгжил	151	58	54	165	17	67	3	8	0	41	9	0
Амьдралын чанар ба дундаж давхарга	90	13	36	87	10	42	6	12	1	4	5	0
Эдийн засаг	177	11	43	165	13	47	16	29	4	2	4	0
Засаглал	99	6	70	99	6	70	3	3	0	0	0	0
Ногоон хөгжил	63	28	41	64	13	41	0	0	0	15	1	0
Амар тайван, аюулгүй нийгэм	117	9	54	116	2	53	6	7	0	7	0	1
Бүс, орон нутгийн хөгжил	71	5	91	57	6	44	57	71	4	3	44	91
Улаанбаатар ба дагуул хот	149	4	77	150	3	77	2	1	1	0	2	1
Нийт дүн	983	138	513	967	73	488	97	137	11	74	65	93

Эх сурвалж: УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол, Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсөл, УАГ.

2.30. УИХ-ын 52 дугаар тогтоолоор нэмэгдсэн зорилт, үйл ажиллагаа нь урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан эсэх, тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой байх шинжийг хангасан зэрэгт нөхцөл байдлын дүн шинжилгээ⁴⁴, бодлогын үр нөлөө⁴⁵, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ⁴⁶ хийсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

“Алсын хараа 2050”-ын зарим зорилт нь тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц шинжийг бүрэн агуулаагүй байна

2.31. “Алсын хараа 2050” бодлогын баримт бичигт тусгасан 47 зорилтын хүрээнд нийт 73 шалгуур үзүүлэлтийг батлахдаа тухайлсан 5 зорилт нь шалгуур үзүүлэлтгүй, 5 зорилт нь тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц шинжийг бүрэн агуулаагүй байна. Тухайлбал:

Шалгуур үзүүлэлтгүй:

Бүс, орон нутгийн хөгжил

- Зорилт 8.2.Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Зорилт 8.3.Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

⁴⁴ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын Дөрөв “Нөхцөл байдлын дүн шинжилгээ”-ний 23-т “Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн асуудлаар хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, шаардлагыг гаргасан тулгамдсан асуудлыг мэдэрч тодорхойлсон баримт бичиг байна” гэж заасан.

⁴⁵ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 9.6. “бодлогын үр нөлөө” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд бий болох өөрчлөлтийг.

⁴⁶ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын Тав “Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ”-ны 24-т “Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна”. 25-т “Эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил, үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө нь их гэж үзсэн тохиолдолд нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно”, 26-т “Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ”

Тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц шинжийг бүрэн агуулаагүй:

Үндэсний нэгдмэл үнэт зүйл

- Зорилт 1.1. Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна;
- Зорилт 1.2. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч Монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно;
- Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын Монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон Монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ;
- Зорилт 1.5. Дэлхий дахинд Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, Монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь Монголчууд, Монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө.

Амьдралын чанар ба дундаж давхарга

- Зорилт 3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бий болгоно.

2.32. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам⁴⁷-ын 54.1⁴⁸-д заасантай бүрэн нийцээгүй, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, дүгнэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

⁴⁷ Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон

⁴⁸ “Бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна”

БҮЛЭГ 3. “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030” БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭЭГҮЙ, ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА

3.1. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг гурван 5 жилээр 3 үе шаттай хөгжүүлэхээр 3 бүлэг, 27 зарчим, 40 зорилт, 20 үндсэн шалгуур үзүүлэлттэйгээр, “Тогтвортой хөгжлийн засаглал”-ын бүлгийн 5 зарчим, 4 зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлоогүй баталсан байна.

3.2. Уг үзэл баримтлалд “...Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно...” гэж тусгажээ.

3.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичиг нь Эдийн засгийн тогтвортой хөгжил, Нийгмийн тогтвортой хөгжил, Байгаль орчны тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн засаглал гэсэн 4 бүлгийн 32 зарчим, 44 зорилтод хуваагдаж байна.

Дүрслэл 12. МУТХҮБ-2030-ийн зарчим, зорилт

Эдийн засаг	Нийгэм	Засаглал	Байгаль орчин
• 22 зорилт • Суурь зарчим 10 • Салбарын хөгжлийг хангах зарчим 3	• 12 зорилт • Салбарын хөгжлийг хангах зарчим 9	• 4 зорилт • Салбарын хөгжлийг хангах зарчим 5	• 6 зорилт • Салбарын хөгжлийг хангах зарчим 5

Эх сурвалж: УАГ

3.4. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийн 2014 оны (суурь түвшин) тоон мэдээллийг хэрхэн тооцсон арга аргачлал, мэдээллийн эх сурвалжийг тодорхой зааж өгөөгүй, тоон үзүүлэлт нь бодит дүнгээс зөрүүтэй байна.

3.5. Аудитаар Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк, НҮБХХ, Дэлхийн эдийн засгийн форум, АНУ-ын Йель болон Колумбын их сургууль зэрэг олон улсын эрх бүхий байгууллагаас гаргаж буй судалгааны тоо мэдээллийг эх сурвалж болгон МУТХҮБ-2030-ын I үе шат (2016-2020)-ны хэрэгжилтийн явц, үр дүнг илэрхийлэх 20 үзүүлэлтийн бодит гүйцэтгэл, үр нөлөөг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

МУТХҮБ-2030-ын үр дүнг илэрхийлсэн үзүүлэлтүүд I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүнг бүрэн хангаагүй байна

1. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт

3.6. МУТХҮБ-2030-д 2016-2030 оны эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байхаар баталсан байна.

3.7. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2016-2018 онд 1.5 хувиас 7.7 хувийн өсөлттэй, 2020 онд -4.6 хувийн агшилттай гарсан байна.

Дүрслэл 13.



Эх сурвалж: УСХ

3.8. Эдийн засгийн үзүүлэлтэд уул уурхайн салбарын оролцоо 2018 онд 5.4 хувийн өсөлттэй, 2016-2020 онд -1.6 хувиас -9.9 хувийн агшилттай, уул уурхайн бус салбарын оролцоо 2016-2019 онд 3.3 хувиас 7.3 хувийн өсөлттэй, 2020 онд -4.3 хувьтай гарсан байна.

Хүснэгт 4. ДНБ-ий өсөлт, бууралт /хувиар/


Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
ДНБ-ий өсөлт, бууралт	1.5	5.6	7.7	5.6	(4.6)
Уул уурхайн салбар	(1.6)	(3.9)	5.4	(1.6)	(9.9)
Уул уурхайн бус салбар	3.3	6.2	6.8	7.3	(4.3)
үүнээс	Хөдөө аж ахуй	5.4	(0.3)	6.5	5.3
	Аж үйлдвэр, барилга	(1.4)	5.7	7.6	8.1
	Үйлчилгээ	4.7	5.6	5.5	7.1
	Бүтээгдэхүүний цэвэр татвар	2.6	23.3	20.4	9.6

Эх сурвалж: УСХ

2. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого

Дүрслэл 14.

3.9. Нэг хүнд ногдох ҮНО нь 2014 онд (суурь түвшин) 4,184.1 ам.доллар, 2016-2020 оны бодит гүйцэтгэл 3,444.0-3,688.0 ам.доллар байсан нь 2014 оноос 383.4-985.4 ам.доллараар буурсан, 2016-2020 оны нэг хүнд ногдох ҮНО-ын хэрэгжилтэд гарсан ахиц -5.6 хувиас -3.7 хувиар буурсан нь 2030 онд 17.500 ам.долларт хүрэх магадлал багатай байна.



Эх сурвалж: УСХ

3. Хүний хөгжлийн үзүүлэлт

3.10. НҮБХХ-өөс 2020 онд эрхлэн гаргасан “хүний хөгжлийн үзүүлэлт”-ээр Монгол Улс 2014 он (суурь түвшин)-д 90 дүгээр байр эзэлж байсан, 2018 онд 0.735 оноо, 2019 онд 0.737 оноо авч өмнөх оноос 0.002 оноогоор өссөн ч эзлэх байр 99 болж 9 байраар ухарсан байна.

3.11. Дээрх үзүүлэлтээр 0.738 оноогоор Сент Винсент ба Гренадин, Суринам улсууд Монгол Улсын өмнө, 0.735 оноогоор Ботсвана Улс хойно жагссан байна.

Хүснэгт 5. Хүний хөгжлийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 /Суурь түвшин/	2016	2017	2018	2019	2020	2030 зорилтот түвшин
Хүний хөгжлийн үзүүлэлт	эзлэх байр	90	-	92	92	99	-	70
	Индекс	0.727	-	0.741	0.735	0.737	-	-

Эх сурвалж: <http://hdr.undp.org/en/data>

4. Дундаж наслалт

Дүрслэл 15.

3.12. Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2016-2020 онд 69.6-аас 70.7 болж өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэх⁴⁹ -ээр тусгасан ч тухайн оны жилийн эцсийн байдлаар зорилтот түвшинд хүрээгүй буюу 0.3 нэгжээр дутуу байна.




Эх сурвалж: УСХ

⁴⁹ Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцооны “Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.” хэмээх зорилт 1-ын I үе шатанд 71-д хүргэх

5. Ядуурлын түвшин

Дүрслэл 16.

3.13. Монгол Улсын ядуурлын түвшин⁵⁰ улсын хэмжээнд 2014 он (суурь түвшин)-д 21.6 хувь байсан бол 2016 онд 29.6 хувьд хүрч, өмнөх үзүүлэлтээс 8 хувиар өссөн, 2018 онд 28.4 хувь болж өмнөх үзүүлэлтээс 1.2 хувиар буурсан ч ядуурлын түвшин 4 жилийн дотор 2014 оны түвшнээс 6.8 хувиар өссөн байна. 2020 оны ядуурлын түвшинг тооцох аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үзүүлэлтийг тооцож тайлагнаагүй байна.



Эх сурвалж: УСХ

6. Өрсөлдөх чадварын үзүүлэлт

Дүрслэл 17.

3.14. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “өрсөлдөх чадварын үзүүлэлт”⁵¹-ээр манай улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт 2016-2019 онуудад суурь оноос буурч, эзлэх байр ухарсанд дэд бүтэц, институт, харилцаа холбоо, мэдээлэл технологи, бүтээгдэхүүний зах зээл бүлгийн үзүүлэлтүүдийн оноо буурсан нь нөлөөлсөн байна.



Эх сурвалж: <https://www.weforum.org/>

7. Бизнес эрхлэлтийн үзүүлэлт

Дүрслэл 18.

3.15. Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг “бизнес эрхлэлтийн үзүүлэлт”⁵²-ээр Монгол Улс 2014 он (суурь түвшин)-д 72-т эрэмбэлэгдэж байсан бол 2016-2017 оны хооронд 62 болж ахисан ч, 2018-2020 оны хооронд 81 болж ухарсан байна.



Эх сурвалж: <https://www.doingbusiness.org/en/rankings>

Байдлыг шийдвэрлэх үзүүлэлт 150 дугаар байрыг эзэлж байгаа нь нөлөөлсөн байна.

8. Байгаль орчны багц үзүүлэлт

3.17. Монгол Улсад байгаль экологийн тэнцвэрт байдлын сөрөг нөлөө сүүлийн 10 жилд 7.6 хувиар нэмэгдсэн⁵³, экологийн тэнцвэрт байдал алдагдсанаас 2020 онд 180 орноос 147-д эрэмбэлэгдэж, бодлого сул ангилалд багтсан байна.

⁵⁰ ядуурлын шугам, хэрэглээ, хувь хүн ерөнхий олонлогт байгаа нийт хүн амын тоо ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүний тооны харьцаагаар томъёогоор бодож гаргадаг байна.

⁵¹ Дэлхийн эдийн засгийн форумаас улс орнуудын өрсөлдөх чадварыг 12 үндсэн бүлэг бүхий үзүүлэлтээр жил бүр хэмждэг бөгөөд 2020 Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн улс орнуудыг өрсөлдөх чадварын үзүүлэлтээр харьцуулан эрэмбэлэхийг түр зогсоосон байна.

⁵² Дэлхийн банкнаас жил бүр Бизнес эрхлэлтийн үзүүлэлтийг тооцохдоо үндсэн 10 үзүүлэлтийн онооны дунджаар гаргадаг байна.

⁵³ АНУ-ын Йель болон Колумбийн их сургуулиас улс орнуудын Засгийн газрын байгаль орчны бодлогын хэрэгжилт, экологийн тэнцвэрт байдалд 11 бүлгийн 32 үзүүлэлтээр судалгаа хийж үр дүнг 2 жилд тутамд тайлагнадаг байна.

Хүснэгт 6. Байгаль орчны багц үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 /Суурь түвшин/	2016	2017	2018	2019	2020	2030 зорилтот түвшин
Байгаль орчны багц үзүүлэлт	эзлэх байр	111	114	-	83	-	147	90

Эх сурвалж: <https://epi.yale.edu/downloads/epi2020report20210112.pdf>

9. Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал

3.18. Монгол Улс 2014 онд 2,995.9 мянган хүн амтай байснаас эдийн засгийн идэвхтэй хүн амын⁵⁴ тоо 1,206.6 мянга буюу нийт хүн амын 40.3 хувь нь байсан бол 2020 онд нийт 3,357.5 мянган хүн амтай болж, эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,250.6 мянга буюу нийт хүн амын 37.2 хувийг эзэлж байна.

3.19. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 84 хувь нь 2014 онд нийгмийн даатгалд хамрагдаж байсан бол 2016-2020 оны хооронд 80.6 – 81.0 хувьтай байгаа нь суурь түвшингээс буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдлын судалгаа

Үзүүлэлт	хэмжих нэгж	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Монгол Улсын нийт хүн ам		2,995.9	3,057.8	3,119.9	3,177.9	3,238.5	3,296.9	3,357.5
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллах хүч	мянган хүн	1,206.6	1,243.9	1,275.7	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6
Нийт хүн амд ажиллах хүчний эзлэх хувь	хувь	40.3	40.7	40.9	42.7	42.0	38.6	37.2
Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	мянган хүн	1,018.6	989.0	1,028.0	1,035.6	1,121.7	987.5	1,013.2
	хувь	84.4	79.5	80.6	76.3	82.6	77.5	81.0

Эх сурвалж: УСХ, УАГ

10. Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт

Дүрслэл 19.

3.20. УСХ-ноос (жини коэффициент) гаргасан⁵⁵ “Орлого, хэрэглээний тэгш бус байдлын 2020 оны тайлан”-д орлогын тэгш бус байдалд хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага байна. ААНБ-ын ажиллагчдын медиан цалин⁵⁶ нь 2020 онд 900.7 мян.төгрөг байгаа нь улсын дундаж цалингаас 319.9 (26.2%) мянган төгрөгөөр бага байна. Дундаж цалин болон медиан цалингийн харьцаа 2020 оны 4 дүгээр улиралд 2015 оны 4 дүгээр улирлаас 3.4 нэгж хувиар холдсон нь ажиллагчдын цалингийн ялгаа ихэссэнийг харуулж байна.



Эх сурвалж: УСХ

Хүснэгт 8. Ажиллагчдын сарын дундаж цалин /2014-2020он/

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Ажиллагчдын сарын дундаж цалин /мян.төг/	796.6	808.0	861.9	944.5	1,002.9	1,124.3	1,220.6

Эх сурвалж: УСХ

⁵⁴ Олон улсын аргачлалын дагуу Эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэг нь тухайн улсын нийт ажиллагсад болон ажилгүйчүүдийн нийлбэрээр тодорхойлогдоно. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг нөгөө талаар тус улсын ажиллах хүч гэнэ.

⁵⁵ “Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт”-ийн 2014 оны суурь түвшний эх үүсвэр тодорхойгүй тул УСХ-оос улирал тутам тооцдог орлогын тэгш бус байдлын жини коэффициентээр орлуулан тооцсон бөгөөд тус үзүүлэлт 0 байх нь төгс тэгш байдлыг, 100 байх нь төгс тэгш бус байдлыг тус тус илэрхийлдэг.

⁵⁶ Медиан цалин нь НДЕГ-ын НДШ төлөлтийн тайланд тухайн улирал/жилд хамрагдсан нийт ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр жагсаахад түүний төв буюу хоёр талыг тэнцүү хэсэгт хувааж буй ажилтны цалингаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, медиан цалин гэдэг нь нийт цалинтай ажиллагчдын авч буй голч цалингийн хэмжээ юм.

11. 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин

Дүрслэл 20.

3.21. Улсын хэмжээнд 2014 оны (суурь түвшин) нялхсын эндэгдлийн тохиолдол 1000 амьд төрөлтөд 15 байсан бол 2016 онд 17 болж суурь түвшингээс 2 нэгжээр өссөн, 2017-2020 онд 14-12 нэгж болж буурсан ч, 2016-2020 онд нялхсын эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 8 болтол бууруулах үр дүнд хүрээгүй буюу төлөвлөснөөс 1.5 дахин их байна.



Эх сурвалж: УСХ

12. 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин

Дүрслэл 21. 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин

3.22. Улсын хэмжээнд 2014 он (суурь түвшин)-д эхийн эндэгдэл 31, 2016 онд 49 болж суурь түвшингээс 18 тохиолдлоор өссөн, 2017-2019 онд 27-23 болж буурсан ч 2020 онд 30 болж өссөн нь хүрэх үр дүн⁵⁷-гээс 5-аар их байна. ЭМЯ, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй "Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь" сэдэвт улсын зөвлөгөөн, эх барихын яаралтай тусламжийн сургалтыг⁵⁸ аймаг, нийслэлийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтнүүдэд зохион байгуулсан ч боловсон хүчнийг чадавхжуулах байдал үр дүнгүй байна.



Эх сурвалж: УСХ

13. Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)

Дүрслэл 22.

3.23. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2020 оны хооронд нийт 99 сургууль (42,361 хүүхэдтэй) ашиглалтад оруулж, ЕБС-ийн хүрэлцээг нэмэгдүүлж, сургуулийн хүртээмжийг сайжруулах, гурван ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог цөөлөх зорилт тавьж ажилласан байна.



Эх сурвалж: УСХ

3.24. ЕБС-ийн бүлэг дүүргэлт 2014 он (суурь түвшин)-д 27 хүүхэдтэй, 2016-2020 оны хооронд 27-30 хүртэл өссөн байна. Бүлэг дүүргэлтийн судалгааг шинээр ашиглалтад оруулсан сургуулийн тоо, хүчин чадалтай харьцуулан тооцоход Засгийн Газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.

14. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ

3.25. ДМАЭМБ /OIE/ -аас улс орнуудад мал амьтны өвчингүй статусыг баталгаажуулан гэрчилгээ олгодог ч Монгол Улс 2020 оны байдлаар гэрчилгээ аваагүй байгаа нь хорио,

⁵⁷ эхийн эндэгдлийг 100000 амьд төрөлтөд 25 болгож бууруулах

⁵⁸ 2019 онд улсын төсвөөс жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээнд зориулж 1.8 тэрбум төгрөг зарцуулсан, эмч сувилагч нарыг чадавхжуулах зорилгоор ӨЭМТ, ЭХЭМҮТ-ийн эмч нарт цахим сургалт, НҮБ-ын Хүн амын сан, НЭМГ хамтран

цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээг тогтоох нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

15. Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ

3.26. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ 2014 он (суурь түвшин)-д 78.2 хувь, 2019 онд 76.8 хувьтай гарч суурь түвшнээс 1.4 хувиар буурсанд Засгийн газраас⁵⁹ улсын хэмжээнд 322.04 мянган га талбайд ойн зурвасыг байгуулсан, 2016-2019 онд 703 булаг шандын эхийг хашиж хамгаалсан, уул уурхайн улмаас эвдэрсэн 800 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн зэрэг үйл ажиллагааны үр дүн нөлөөлжээ.

Хүснэгт 9. Цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 /Суурь түвшин/	2016	2017	2018	2019	2020	2030 зорилтот түвшин
Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	78.2	-	-	-	76.8	-	68

Эх сурвалж: Байгаль орчны төлөв байдлын тайлан

16. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ

3.27. БОАЖЯ-ншаас жил бүр “Байгаль орчны төлөв байдлын тайлан”-г гаргадаг бөгөөд Монгол Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ 2014 онд (суурь түвшин) 17.4 хувь байсан⁶⁰, 2020 онд 21.0 хувийг эзэлж⁶¹ суурь түвшнээс 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 10. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 /Суурь түвшин/	2016	2017	2018	2019	2020	2030 зорилтот түвшин
Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	17.4	17.5	17.4	17.8	20.11	21.00	30

Эх сурвалж. Байгаль орчны төлөв байдлын тайлан, БОАЖЯ

17. Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо

Дүрслэл 23.

3.28. Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаад жуулчдын тоог⁶² 2020 онд 1 саяд хүргэх үйл ажиллагааны хэрэгжилт 2016-2019 онуудад 404.2 мянган жуулчдаас 577.3 мянга хүртэл нэмэгдсэн ч 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас шалтгаалан тус үзүүлэлт 58.9 мянга болтол буурсан байна.



Эх сурвалж: УСХ

18. Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх

3.29. Цахилгаан эрчим хүчийг 2014 онд 4,285.2 сая.квт-ыг хэрэглэгчдэд борлуулснаас орон сууц болон гэр хорооллын хэрэглэгчдэд 1,156.6 сая.квт цахилгаан эрчим хүчийг борлуулсан байна.

⁵⁹ Засгийн газрын 2010 оны 90 дүгээр тогтоолоор баталсан Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт “...цөлжих эрсдэлтэй газар нутгийг цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, элсний нүүдлийг зогсоох, уул уурхайн нөхөн сэргээлт хийх, тариалангийн талбайн хөрс хамгаалах, усалгааны систем, ойн зурвас байгуулах, бэлчээрийн даацыг тохируулах болон цөлжиж байгаа газар нутгийг нөхөн сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах, усан сан байгуулах, гангийн нөлөөг бууруулах...” 5 жилд 1 удаа судалгаа хийж тайлан гаргадаг байна.

⁶⁰ 27.2 сая га талбай


⁶¹ 31.5 сая га талбай болсон

⁶² Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 2020 оны зорилтот түвшинг 1.0 саяд хүргэх

Дүрслэл 24.

3.30. Мулсад 2014 онд нийт 823,412 өрх бүртгэлтэй байснаас Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр 504,835 өрхийг хангасан нь нийт өрхийн 61.3 хувийг эзэлж байсан байна.

3.31. Монгол Улсын нийт өрхийг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилтын биелэлт 2020 онд нийт өрхийн 74.8 хувь нь цахилгаан эрчим хүчинд холбогдож суурь түвшинтэй⁶³ харьцуулахад 13.5 пунктээр нэмэгдсэн үр дүнтэй байна.



3.32. Цахилгаан эрчим хүчинд холбогдсон өрхийн тоо энэ өсөлтийн хурдаар⁶⁴ хадгалан өсвөл 2030 оны зорилтот түвшинд⁶⁵ хүрэхэд 8.8 хувиар дутах магадлалтай байна.

19. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ

Дүрслэл 25

3.33. Нийт экспортод эзлэх боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жинг 15 хувьд хүргэхээс 2020 онд 7 хувьд хүргэж, хүрэх түвшин хангагдаагүй байна.

3.34. 2020 онд өмнөх оноос мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний экспорт 64.6 сая ам. доллар, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 279.5 сая ам.доллар, авто, агаар, усан замын бүтээгдэхүүний экспорт 4.2 сая ам доллар хүртэл буурсан нь нөлөөлжээ.



Хүснэгт 11 Нийт боловсруулах үйлдвэрлэлийн экспорт /сая ам.доллар/

	2014	2016	2017	2018	2019	2020
Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн	38.8	85.1	135.5	124.7	110.7	64.6
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	338.8	300.2	335.5	409.8	434.7	279.5
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	35.1	70.0	17.0	24.7	78.6	4.2
Бусад	164.6	215.5	182.0	236.7	199.2	182.1
Нийт Боловсруулах үйлдвэрлэлийн экспорт	577.3	670.8	670.0	795.9	823.2	530.3

Эх сурвалж: УСХ

20. Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь

3.35. Газрын тос боловсруулах үйлдвэрийг Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор БНЭУ-ын ЭкСим банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр эхлүүлсэн ч /үйлдвэрийн барилгын ажил эхлээгүй, үйлдвэрийн түүхий тос дамжуулах шугам хоолойн төслийн ТЭЗҮ батлагдаагүй/ ашиглалтад ороогүй⁶⁶, 2020 оны эцэст гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг 100% импортоор авч хэрэглэж байна.

⁶³ Суурь түвшин: 2014 онд 61.3 хувь.

⁶⁴ Жилийн дундаж өсөлт 2.0 хувь

⁶⁵ 2030 онд 100.0-д хүргэх зорилттой.

⁶⁶ Дээрх төслийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн

Макро эдийн засгийн бодлогын суурь зарчим бүрэн хангагдаагүй байна

3.36. Засгийн газар МУТХҮБ-2030-ын Эдийн засгийн тогтвортой хөгжил, нийгмийн тогтвортой хөгжил, байгаль орчны тогтвортой хөгжил, засаглалын тогтвортой хөгжлийн хүрээнд тусгасан 44 зорилтын I үе шат (2016-2020)-ны хэрэгжилт, үр дүнг үнэлж тайлагнаагүйгээс зорилтын үр нөлөөг тооцох боломжгүй байна.

3.37. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2016 онд -20.1 хувь, 2020 онд -16.7 хувьтай гарсан нь 2020 онд 15 хувь хүртэл бууруулах, нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах гэсэн зарчим бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 12.


Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дээд хязгаар, тэнцвэржүүлсэн тэнцэлд ДНБ-д эзлэх /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ хувь

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	Тэрбум төгрөг	5,835.0	7,274.9	9,345.1	10,905.5	9,463.8
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ		9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,904.3
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл		(3,660.3)	(1,742.4)	(27.8)	(756.2)	(4,440.4)
ДНБ-д эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 15 хувь хүртэл бууруулах;	хувь	-20.1%	-10.8%	-4.8%	-7.5%	-16.7%
2020 онд 15 хувь хүртэл бууруулах зорилтот түвшингийн зөрүү		-5.1	4.2	19.8	7.5	-1.7

Эх сурвалж. УСХ, МУТХҮБ-2030

Дүрслэл 26.


3.38. Төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцоноор/-ыг 2020 онд 35 хувь хүртэл бууруулах зарчим 2017-2019 онд хангагдсан бол, 2016 онд 4.8 хувиар, 2020 онд 2.6 хувиар тус тус хэтэрсэн байна.



Эх сурвалж. УСХ

Дүрслэл 27.

3.39. Засгийн газрын өрийн (ӨҮЦ), ДНБ-ий эзлэх хувь нь Өрийн удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасан өрийн хязгаарт нийцэж байгаа хэдий ч хуульд өөрчлөлт оруулж, тусгай шаардлагыг нэмж байгаа нь өрийг тасралтгүй өсгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Эх сурвалж. УСХ

3.40. Холбогдох хуулиар тогтоосон Засгийн газрын өрийн дээд хязгаарыг 2016-2020 оны нийт өрийн үлдэгдэлтэй харьцуулахад 2017-2018 онд дээд хязгаар дотор байсан ч, 2016 онд -981.0 тэрбум, 2019 онд -4,363.5 тэрбум, 2020 онд -5,806.3 тэрбум төгрөгөөр өрийн дээд хязгаараас давсан байна.

3.41. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдээр тогтоосон өрийн тусгай шаардлагын үзүүлэлт нь ОУВС болон Дэлхийн банкнаас тогтоосон өрийн тогтвортой байдлын үзүүлэлтээс хэтэрсэн байна.

Хүснэгт 13

3.42. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн⁶⁷ 2016-2020 оны жил бүрийн төлөвийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Фитч (Fitch Ratings), Мүүдис (Moody's Investors Service), Стандарт энд Пүүрс (S&P Global Ratings) агентлагаас гаргасан урт хугацааны үнэлгээгээр 2016-2017 онд Саа1 тогтвортой, В-, сөрөг, В-, тогтвортой түвшнээс 2018-2019 оны хооронд В, В3, тогтвортой болон нэмэгдсэн ч⁶⁸ 2020 онд В3 сөрөг, В тогтвортой байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд багтаж байна.


Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үзүүлэлтийн судалгаа			
Он	Мүүдис (Moody's Investors Service)	Фитч (Fitch Ratings)	Стандарт энд Пүүрс (S&P Global Ratings)
2016	Саа1, тогтвортой	В-, сөрөг	В-, тогтвортой
2017	Саа1, тогтвортой	В-, сөрөг	В-, тогтвортой
2018	В3, тогтвортой	В, тогтвортой	В, тогтвортой
2019	В3, тогтвортой	В, тогтвортой	В, тогтвортой
2020	В3, сөрөг	В, тогтвортой	В, тогтвортой

Эх сурвалж: www.mongolbank.mn, www.moody.com, www.fitchratings.com

3.43. Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн мэдээг Монголбанкнаас 2014 оны 7 дугаар сараас /өмнө 3 сарын хоцрогдолтой мэдээлж байсан/ 1 сарын хоцрогдолтой мэдээлж ирсэн байна.

Дүрслэл 28.

3.44. Гадаад валютын улсын нийт албан нөөцийн хэмжээ 2014-2017 оны 10 дугаар сарын хооронд 1649.9-1694.4 сая. ам.долларт хэлбэлзэж байсан бол 2017 оны 12 дугаар сараас 2020 оны 12 дугаар сарын хооронд 3008.1-4534.2 сая.ам.доллар болж нөөцийн хэмжээ нэмэгдэн, жилийн өөрчлөлтийн хувь 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 02 дугаар сарын хооронд 132.0-182.8 хувьд хүрсэн байна.



Эх сурвалж: www.mongolbank.mn, Монголбанкны статистик мэдээ

3.45. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2018 онд 3,550.0 сая, 2019 онд 4,349.0 сая, 2020 онд 4,534.0 сая.ам.доллороор өссөнөөс гадаад валютаар илэрхийлэгдсэн нөөц 76.6-87.9 хувь, ОУВС-д байршуулсан хөрөнгө 0.2 хувь, зээлжих тусгай эрх 1.6-1.0 хувь,

⁶⁷ Монгол Улсын зээлжих зэрэглэлд Нэг хүнд ногдох ДНБ, Авлигын түвшин, Инфляц, Төсвийн тэнцэл, Ажилгүйдлийн түвшин, Эдийн засгийн урт хугацааны өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна.

⁶⁸ S&P болон Fitch агентлагийн үнэлгээгээр BBB түвшнээс, Moody's агентлагийн үнэлгээгээр Ваа түвшнээс доогуур тохиолдолд хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд ангилагддаг бөгөөд манай улс эдгээр түвшнээс доогуур байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд ангилагдаж буйг харуулж байна.

мөнгөжсөн алт 21.7-10.9 хувийг эзэлж, нийт нөөцийн хэмжээг 2019 онд өмнөх оноос 22.5 хувиар, 2020 онд 4.5 хувиар өсгөж бүрдүүлсэн байна.

Хүснэгт 14.

Гадаад валютын албан нөөцийн 2018-2020 оны 12 дугаар сарын /үлдэгдэл/ бүрдүүлэлтийн судалгаа


Индикаторын нэр	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он
А. Албан нөөц хөрөнгө	сая ам.	3,550	4,349	4,534
1. Гадаад валютаар илэрхийлэгдэх нөөц	доллар	2,717	3,175	3,988
(a) Үнэт цаас		1,661	1,516	2,366
(b) Нийт харилцах, хадгаламж:		1,056	1,658	1,622
2. ОУВС-д байршуулсан хөрөнгө		8	8	8
3. Зээлжих тусгай эрх (ЗТЭ)		55	49	46
4. Мөнгөжсөн алт (алтны хадгаламж, алтны своп хэлцэл)		769	1,117	493

Эх сурвалж: www.mongolbank.mn Монгол банкны статистик мэдээ

3.46. Монголбанк нь хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг нам түвшинд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлэхдээ иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих зорилготой байна

3.47. Инфляцын зорилтот түвшинг 2016 онд 7.0 хувь, 2017-2020 онд 8.0 хувьтай байхаар төсөөлснөөс жилийн инфляци 2016 онд 1.3, 2017 онд 6.4, 2019 онд 5.2, 2020 онд 2.3 хувь байсан нь зорилтот түвшин дотор, 2018 онд 8.1 хувь байсан нь зорилтот түвшингээс 0.1 нэгжээр өндөр байжээ.


Дүрслэл 29.



Эх сурвалж: www.mongolbank.mn Монголбанкны статистик мэдээ

3.48. Жилийн инфляци 2018 онд 8.1 хувьд хүрч зорилтот түвшингээс 0.1 нэгжээр өндөр гарахад шатахуун, хатуу түлшний үнийн өсөлт 41 хувьтай байсан нь голлох нөлөөг үзүүлсэн бол 2020 оны жилийн инфляци 2.3 хувь болоход Төрөөс шатахуун, хатуу түлшний үнийг бууруулах бодлого барьсан нь нөлөөлсөн байна.

Дүрслэл 30.



Эх сурвалж: www.mongolbank.mn Монголбанкны статистик мэдээ

3.49. Монгол Улсын төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2014 онд Английн 1 фунт 2,939.0 төг, Европын холбооны Улсын 1 евро 2,295.4 төг, АНУ-ын 1 ам.доллар 1,888.4 төг, БНХАУ-ын 1 юань 304.6 төг, ОХУ-ын 1 рубль 34 төг, Японы 1 иен 15.8 төг, БНСУ-ын 1 вон 1.7 төгрөгтэй тэнцэж байжээ.

3.50. Харин Монгол Улсын төгрөгийн евротой харьцах ханш 2015 онд 114.2 нэгж, АНУ-ын ам.доллартой 2017 онд 62.4 нэгж, ОХУ-ын рубльтэй 2015 онд 7.0 нэгж, 2018 онд 4.0 нэгж, 2020 онд 6.0 нэгжээр тус тус чангарч байсан бол 2015-2020 оны хооронд төгрөгийн ханш евротой 19.2-301.4 нэгж, юаньтай 2.7-с 43.8 нэгж, иентэй 0.8-с 2.5 нэгж, вонтой 0.4-с 0.3 нэгжээр тогтмол суларч, төгрөгийн ханш тогтворгүй байна.

Дүрслэл 31.



Эх сурвалж: Монголбанкны 2020 оны статистик мэдээ

3.51. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах хүрээнд “МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө⁶⁹”-ний 5.2.6. “Монгол Улсаас гадаад улстай байгуулсан худалдаа, хөрөнгө оруулалт, давхар татварын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, Монгол Улсын эрх ашигт нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ” заалтын хүрээнд дараах 4 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлжээ.

- Монгол Улсын 43 улстай хийсэн Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих хэлэлцээрийг шинэчлэх- ГХЯ болон ҮХГ хамтран Монгол Улсын зүгээс санал болгох Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих хэлэлцээрийн загварыг боловсруулж 2019 оны 3 сарын 6-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар баталсан байна.
- Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт (АПТА) нэгдэн орох-Монгол Улс АНДХХ-т нэгдэн орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, улмаар нэгдэн орох нөхцөлийг 2018 оны 9 дүгээр сард хангасан. Улсын Их хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийг соёрхон баталсан байна.
- БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг хийж, хэлэлцээрийг байгуулах-Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНСУ-ын Эрчим хүч, үйлдвэр, худалдааны яам хамтран “Монгол Улс, БНСУ хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)” байгуулах асуудлаарх Хамтарсан судалгааг хийж, хэлэлцээр байгуулах, хэлэлцээг эхлүүлэхэд Монголын тал бэлэн байгаа талаар Өмнөд Солонгосын талд албан ёсоор мэдээлж, хариу хүлээж байна.
- Япон Улстай давхар татварын хэлэлцээр байгуулах - 2017 оны 1 дүгээр сард хоёр улсын Сангийн яамны төлөөлөгчид Улаанбаатар хотноо анхан шатны техникийн уулзалт хийсэн. УИХ-ын 2019 оны ээлжит бус чуулганы 3 дугаар сарын 22 -ны өдрийн хуралдаанаар Татварын багц хуулийн өөрчлөлтүүдийг баталсныг Японы Сангийн яамны холбогдох газарт 2019 оны 5 дугаар сард танилцуулж, 2020 оны 1 дүгээр улиралд Токио хотноо техникийн уулзалт хийх, Монгол талаас Сангийн яам “Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр” -ийн хүрээнд уг хэлэлцээрийг 2021 онд багтаан байгуулахаар төлөвлөсөн байна.

⁶⁹ Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан

“МУТХҮБ-2030” бодлогын баримт бичгийн дөрвөн бүлгийн 44 зорилтын I үе шатны 127 хүрэх түвшингээс 10.2 хувь нь үр дүн хангагдсан, 42.5 хувь нь үр дүн хангагдаагүй, 47.3 хувь хүрэх үр дүн тодорхойгүйгээс үр нөлөөг нь тооцох боломжгүй байна

3.52. “МУТХҮБ-2030”-ын Эдийн засгийн тогтвортой хөгжил, Нийгмийн тогтвортой хөгжил, Байгаль орчны тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн засаглал 4 бүлгийн 44 зорилтын I үе шатанд 127 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 13 буюу 10.2 хувь, үр дүн хангагдаагүй 54 буюу 42.5 хувь, хүрэх үр дүн тодорхойгүй 60 буюу 47.3 хувийг эзэлж байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 15

МУТХҮБ-2030-ын 4 зорилгын I үе шат (2016-2020)-д хүрсэн үр дүнгийн нэгтгэл

№	Зорилго	Зорилтын тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Хүрэх үр дүн		
				хангасан	хангаагүй	тодорхойгүй
1	Эдийн засгийн тогтвортой хөгжил	22	74	7	31	36
2	Нийгмийн тогтвортой хөгжил	12	35	5	13	17
3	Байгаль орчны тогтвортой хөгжил	6	14	1	10	3
4	Тогтвортой хөгжлийн засаглал	4	4	0	0	4
МУТХҮБ-2030-ын нийт дүн		44	127	13	54	60

Эх сурвалж: УАГ

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 22 зорилтын 74 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 7, үр дүн хангагдаагүй 31, хүрэх үр дүн тодорхойгүй 36 байна

3.53. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад Макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх хүрээнд хөдөө аж ахуй, аж үйлдвэр (хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл), аялал жуулчлал, уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн 22 зорилтыг дэвшүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарын 4 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.54. “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ” зорилтын хүрээнд үр дүнг хангаагүй 2, хүрэх түвшин тодорхойгүй 2 байна.

- “Монгол мал үндэсний хөтөлбөр”-т⁷⁰ 2021 оны эхэнд малын тоо 36.5 сая.толгой байхаар заасан ч 2020 оны жилийн эцэст 67.1 сая толгой буюу 30.6 сая.толгойгоор хэтэрч, зохистой харьцаа алдагдсан байна.


3.55. “Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ” зорилтын хүрээнд: хүрэх түвшин тодорхойгүй 1, үр дүнд хүрсэн 2, үр дүнд хүрээгүй 1 байна.

- Гахай, тахиан аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох үйл

⁷⁰ УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн Тав.Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтээр малын тоо 2008 оны суурь түвшин-43.3 сая толгой, /2012 онд 33.3 сая толгой, 2015 онд 35.3 сая толгой, 2021 оны эхэнд 36.5 сая толгойд хүрэх/

ажиллагааны хэрэгжилтэд Монгол дахь фермерийн аж ахуйн гахайн тоо толгой 2017-2020 онд 32.1 мянгаас 21.3 мянга болтол буурсан. Харин тахиан тоо толгой 767.9 мянгаас 956.0 хүртэл нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 32.



Эх сурвалж: ХХААХҮЯ

3.56. “Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх үр дүнг хангаагүй 4, хүрэх үр дүн тодорхойгүй 1 байна.

- Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг эдлэншүүлэлтийн технологи нэвтрүүлэлт 70 хувьд хүргэхээс 54 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн. усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 65 мянган га-д хүрэхээс 63 мянган га-д хүрсэн байна.
- жилд шаардагдах бордооны хангамжийг 50 хувьд хүргэхээс 40 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 75 хувьд хүргэхээс 12 хувьд тус тус хүрсэн байна.

3.57. “Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 1, үр дүн хангагдсан 1 байна.

3.58. Аялал жуулчлалын салбарын “Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно” зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүнг хангаагүй 1, хүрэх түвшин тодорхойгүй 2 байна.

Аж үйлдвэрийн салбарт 4 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:


3.59. “Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 2, үр дүн хангагдаагүй 2 байна.

- Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэхээс 7.0 хувьд хүрсэн байна.
- Арьс шир боловсруулалт 2020 онд 36.2% хүрч ноолууран түүхий эд боловсруулалт 25.2%-д хүрсэн нь зорилтот түвшин буюу 60%-д хүрээгүй байна.

3.60. “Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 1, үр дүн хангагдаагүй 2 байна.

- Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 6 хувийг, сүүний 15.4 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан нь хүрэх үр дүнг хангаагүй байна.

Дүрслэл 33



Эх сурвалж: ХХААХҮЯ

3.61. “Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 1, хүрэх түвшин тодорхойгүй 7 байна.

3.62. “Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 1 байна.

- Дарханы жилд 20'000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх чадалтай төмөрлөгийн үйлдвэрийн 2017 онд ашиглалтад орсон. “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах” төсөл 2017 онд эхэлсэн бөгөөд ТЭЗҮ-г тухайн онд багтаан боловсруулсан байна.
- Дэлхийн банкнаас “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” өөр санхүүжсэн, Уул уурхай, хар төмөрлөгийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжих Төмөртэйн ордны уурхайн нөлөөллийн бүсэд иргэдэд газар олгосон асуудал шийдэгдээгүйн улмаас тус төсөл 2018-2019 онд буюу 2 жилээр удааширсан, жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулаагүй нь хүрэх үр дүнг хангаагүй шалтгаан болсон байна.

Эрдэс баялгийн салбарын 2 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.63. “Геологийн салбарын хөгжлийг дэмжих” зорилтын хүрээнд үр дүн хангагдсан 2, хүрэх түвшин тодорхойгүй 1 байна.

- Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын иж бүрдэл зургийн К, L, М (N) хавтгайн судалгааны үр дүн 2020 оны жилийн эцсийн байдлаар К хавтгайн суурин боловсруулалт 100%, L хавтгайн суурин болон хээрийн судалгааны ажил 50%, М болон N хавтгайн 25%-д судалгааг хийж 2016-2020 оны хооронд нийт 3.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэсэн байна.
- Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх ажил зорилтот түвшинд хүрсэн бөгөөд 2016-2020 онд нийт 29.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.
- Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх, Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх... гэсэн арга хэмжээг тусгаж⁷¹ 2016-2020 оны хооронд нийт 43.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3.64. “Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 3 байна.

- “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг баталсан,

⁷¹ Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн 2.59-т “Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ” зорилт

- 20-с доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах, хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2016-2020 онд гадаадын зээлээр 18.5 тэрбум, тусламжаар 5.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн ажлын үр дүн тодорхойгүй байна.
- Говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий Тавантолгойн 450 МВт-ын ДЦС барих арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрэхээс төслийн явц 5 хувьтай, нийт төсөв 142.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Дэд бүтцийн салбарын 7 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

Дүрслэл 34.

3.65. “Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно” зорилтын хүрээнд эрчим хүчний хэрэгцээний 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангахаас 80.7 хувийг хангасан ч зорилтот үр дүнд хүрээгүй байна⁷².



Эх сурвалж: Эрчим хүчний статистик үзүүлэлт 2014-2020 оны цахим сэтгүүл

3.66. “Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20 хувьд хүрэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах” зорилтын хүрээнд Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл 2020 онд 9.1 хувийн, Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нь 18.3 хувийн гүйцэтгэлтэй нь үр дүнд хүрээгүй⁷³, “цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах” хүрэх үр дүн тодорхойгүй байна.

Хүснэгт 16.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, суурилагдсан хүчин чадлын 2016-2020 оны судалгаа

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 /Суурь түвшин/	2020 оны зорилтот түвшин	2016	2017	2018	2019	2020	Үр дүн	
									зөрүү	хангагдсан
Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл	хувь	2.83	20	1.5	4.2	7.1	9.4	9.1	10.9	хангаагүй
Сэргээгдэх эрчим хүчний /суурилагдсан хүчин чадал/ эзлэх хувийг 20-д хүргэх,	хувь	байхгүй	20	6.9	11.8	16.6	17.7	18.3	1.7	хангаагүй
Цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.		байхгүй	Цөмийн эрчим хүч ашиглах хүрэх үр дүн тодорхойгүй							хангаагүй

Эх сурвалж: Эрчим хүчний статистик үзүүлэлт 2014-2020 оны цахим сэтгүүл

3.67. “Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ” зорилт 3-ын хүрээнд 4 хүрэх үр дүнг дэвшүүлснээс үр дүнг хангасан 1, хангаагүй 3 байна.

- Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлэх арга хэмжээг 2016-2020 оны хооронд Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай 1984.943 км авто замыг ашиглалтад оруулсан байна.
- Бүс нутгийн ложистикийг хөгжүүлэх төсөл “Замын-Үүд тээвэр ложистикийн төвийг⁷⁴ байгуулсан. “Хөшигийн хөндийд тээвэр ложистикийн төв байгуулах” төслийг санхүүжүүлэх зээлдүүлэгч

⁷² Эрдэнэтийн ДЦС-ыг 35 мВт-аар өргөтгөх төслийн хэрэгжилт 85 хувийн гүйцэтгэлтэй, ДЦС-III-ын суурилагдсан хүчин чадлыг 250 мВт-аар нэмэгдүүлэх төсөл хөрөнгө оруулагч шийдэгдээгүй, Чойбалсангийн ДЦС-ыг 50 мВт-аар өргөтгөх төсөл 2019 онд гэрээ үзэглэсэн ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр төслийн хэрэгжилт 17 хувийн гүйцэтгэлтэй. Төвийн эрчим хүчний системд 160 мВт.ц багтаамжтай цэнэг хураагуурын станц барих төсөл /төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан/ эхлээгүйтэй тус тус холбоотой байна.

⁷³ Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станц барих төслийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2019 онд ТЭЗҮ боловсруулах судалгааны ажил, 2020 онд улсын тусгай хэрэгцээний 28000 га газарт хээрийн судалгааны ажлыг хийсэн, гадаад зээлийн хөрөнгөөр 2019-2020 онд нийт 1.5 тэрбум, тусламжаар 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан ч төслийн бэлтгэл хангагдаагүй байна.

⁷⁴ АХБ-ын 2719-MON(SF) төслийн хүрээнд нийт 25,358.0 мян.ам доллар буюу 87.1 тэрбум төгрөгийн гадаадын зээлийн хөрөнгөөр, санхүүжүүлэн 2018 онд ашиглалтад хүлээн авсан.

байгууллагыг эцэслээгүй⁷⁵, Алтанбулагт ложистикийн төв байгуулах⁷⁶, “Үндэсний тээвэр, ложистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах” ажил хэрэгжээгүй байна.

- “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн 1435 мм-ийн царигтай⁷⁷, 208.5 км төмөр замын барилгын ажил 2020 оны байдлаар 60 хувийн гүйцэтгэлтэй, бүрэн хэрэгжээгүй; “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барих судалгааны ажлын явцад төмөр зам барих чиглэл нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарч, төмөр замын чиглэлийг өөрчлөх болсон, “Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлын санхүүжилт шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

3.68. “Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ” зорилтын хүрээнд 1 үр дүн хангагдаж, үр дүн хангагдаагүй 2, хүрэх түвшин тодорхойгүй 1 байна. Үүнд:

- Төв аймгийн Хөшгийн хөндийд “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал” барих төсөл хэрэгжиж дууссан байна⁷⁸.
- Аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэхээр Говь-Алтай аймгийн “Алтай”, Завхан аймгийн “Доной” нисэх буудлууд ашиглалтад орсон, Хэнтий аймгийн “Өндөрхаан” нисэх онгоцны буудлыг өргөтгөн шинэчилж, ЗС ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай болгох төсөл⁷⁹ хэрэгжүүлэх ажил 55 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Засгийн газрын 2018 оны 120 дугаар тогтоолоор “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, 2020 оны эхний хагас жилийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувьтай байна.

3.69. “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 3 байна.

3.70. “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 2, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний онцлогт тохирсон арга хэмжээг НҮБХХ-өөс 2017-2020 оны хооронд NAMA төслийн хүрээнд Барилгын хүлэмжийн хийн ялгарлын тооллогын <http://ghgconstruction.gov.mn/> цахим систем, Барилгын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжээг тооцох БД23-105-20 аргачлал, “Барилгын дулаан хамгаалалт” БНБД25-01-20 барилгын норм, дүрэм -ийг баталж, Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-д бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд Барилгын дулаан алдагдлын бууралт 2021 онд 20 хувь хүргэх гэж заасан I үе шатны хүрэх үр дүн хангагдаагүй байна.

3.71. “Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө” зорилтын хүрээнд хүрэх түвшин тодорхойгүй 1, үр дүн хангагдаагүй 2 байна.

- Монгол Улсын 21 аймгийн 331 сумаас 320 сум өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдож, нийт үүрэн холбооны хэрэглэгчийн тоо 2016-2020 оны хооронд 3,119.9 -3,357.5 мянган хүн болсон нь хүрэх үр дүнг хангасан байна.
- Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын⁸⁰ “Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц” зорилтын хүрээнд Ази, Европыг холбосон өндөр хурдны сүлжээний мэдээллийн урсгалын хэмжээг⁸¹ 2020 онд 10 дахин өснө гэж тусгаасан ч олон улсын транзит дамжуулах сүлжээний мэдээллийн урсгал 2018-2019 оны эцэст 135-640 Гбит/сек хүрч 2020 онд 1200 Гбит/сек хүрэх үр дүнг хангаагүй байна.

⁷⁵ Зам, тээврийн салбарын бодлогын 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад арга хэмжээг тусгасан

⁷⁶ “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн “3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх”

⁷⁷ УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор уг төмөр замыг 1435 мм-ийн царигтай байхаар шийдвэрлэсэн.

⁷⁸ Монгол Улсын Засгийн газар болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк хооронд 2008-2019 онуудад MON-P8, MON-P12 зээлийн хүрээнд нийт 64.8 тэрбум иен буюу 600.0 сая ам долларын хөрөнгөөр боссон.

⁷⁹ Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгө

⁸⁰ Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

⁸¹ 2016 /суурь түвшин/ онд 120 Гбит/сек байсан

Макро эдийн засгийн 3 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.72. “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна” зорилтын хүрээнд улсын төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас ихгүй байх үр дүн хангагдаагүй байна.

Хүснэгт 17.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2016-2020 он тус бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлээр баталсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцвэржүүлсэн зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-ий эзлэх хувь, жил бүрийн бодит гүйцэтгэлийн судалгаа

Үзүүлэлт		хэмжих нэгж	Төсвийн хүрээний мэдэгдэл, хуулиар баталсан дүн				
			2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Төсвийн тусгай шаардлагад	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ⁸²	тэрбум төгрөг	5,348.2	6,537.1	7,231.4	9,676.5	11,797.8
	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ⁸³		9,694.4	9,154.5	9,651.5	11,589.8	13,872.6
	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл		-4,346.2	-2,617.4	-2,420.1	-1,913.3	-2,074.7
	ДНБ-д эзлэх хувь	хувь	-18	-9.5	-8	-5.4	-5.1
ТХҮБ-2030-д тусгасан	Улсын төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас ихгүй байхаар төлөвлөсөн дүнгийн зөрүү		20	11.5	10	7.4	7.1

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2016-2020 он тус бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, ТТБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.6, 19.9 дэх хэсэг. МУТХҮБ-2030-ын Макро эдийн засгийн бодлого зорилт

3.73. “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 2, хүрэх түвшин тодорхойгүй 2 байна.

- Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн “Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлж...” гэсэн хүрэх үр дүнг тусгасан, Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, СЗХ-ны даргын хамтарсан А-58/51/134 дугаар тушаалаар “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, I үе шатны хүрэх үр дүн хангагдсан эсэх нь тодорхойгүй, тайлагнаагүй байна.

3.74. “Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 3, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ) /ДНБ-ий эзлэх хувь нь 2016-2020 онд ТТБТХ-ийн төсвийн тусгай шаардлагад нийцсэн ч, МУТХҮБ-2030-ын Зорилт 3⁸⁴-ын I үе шат (2016-2020)-ны “Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийг 58.6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах” зорилтот түвшинг 2019 онд 55.6 хувиар хангасан ч ДНБ-д эзлэх хувь 2016 онд 78.8, 2017 онд 72.5, 2018 онд 58.9, 2020 онд 62.3 хувь байсан нь хүрэх үр дүнг хангаагүй байна.

Хүснэгт 18.

2016-2020 он тус бүрийн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл, үүнээс гадаад өрийн хэмжээ, хуулиар тогтоосон хязгаар, ДНБ-ий эзлэх хувийн судалгаа

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020
Засгийн газрын нийт өр	тэрбум төгрөг	22,280.1	22,751.6	22,367.0	23,915.1	27,898.6
Засгийн газрын гадаад өр		12,363.8	16,857.8	18,865.6	20,443.5	24,851.4
Засгийн газрын өр (ӨҮЦ)		18,861.0	20,212.1	18,955.9	20,525.6	23,024.3

⁸² Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого” гэж гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь орлогын нийлбэрээс тухайн төсвийн жилд Ирээдүйн өв санд хуримтлагдсан төсвийн орлогыг хассан дүнг;

⁸³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл” гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлагын зөрүүг;

⁸⁴ МУТХҮБ-2030-ын Зорилт 3-ын “Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ”

ТТБТХ-ийн ⁸⁵ өрийн ДНБ-ий хязгаар	хувь	88	85	80	75	70
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		78.8	72.5	58.9	55.6	62.3
Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийг 58.6 хувиас хэтрүүлэхгүй		58.6				
Зорилтот түвшингийн нийцэл, зөрүү		-19.4	-13.9	-0.3	3	-3.7

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2016он, 2017 он, 2018 он, 2019 он, 2020 он тус бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, ТТБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь, 19.9 дахь заалт. МУТХҮБ-2030-ийн Макро эдийн засгийн бодлого зорилт

3.75. Бизнесийн таатай орчин зорилтын хүрээнд үр дүн хангагдаагүй 1, хүрэх түвшин тодорхойгүй 2 байна.

- Засгийн газраас 2018 онд “Монгол экспорт” хөтөлбөрийг 2 үе шаттай 2017-2022 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Хөтөлбөрт тусгагдсаны дагуу экспортын бүрдүүлэлт хийх хугацаа, зардал⁸⁶ 2016 онд 115 цаг байсан бөгөөд 2020 онд 134 цаг болж нэмэгдсэн байна.

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 12 зорилтын 35 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 5, үр дүн хангагдаагүй 13, хүрэх үр дүн тодорхойгүй 17 байна

Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдлын 3 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.76. “Ядуурлын бүх төрлийг эцэс болгох” зорилтын хүрээнд “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-өөр халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх, хүнсний хангамж шаардлагатай ядуу, орлого багатай хэсэгт хүнс тэжээлийн дэмжлэг, тэтгэмжийн хэмжээг 20 хувиар, хамрагдах өрхийн тоо хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн ч ядуурлын түвшин⁸⁷ 18 хувьд хүрээгүй, хүрэх үр дүн хангагдаагүй байна.

3.77. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 3, хүрэх түвшин тодорхойгүй 2 байна.

- ХЭДС-ийн дэргэд 6 төсөл хөтөлбөр⁸⁸ хэрэгжүүлсэн ч үр дүн хангагдаагүй байна. Гарааны бизнесийг дэмжих, ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд МСҮТ-ийн сургалт, дадлагын орчныг сайжруулахаар Төрийн өмчийн 19, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 13 дадлагын байр байгуулж, их засварын ажилд 15 тэрбум, сургалтын техник, тоног төхөөрөмж худалдан авахад 12 тэрбум төгрөг зарцуулсан, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжихээр эргэн төлөгдөх нөхцөлтэй 3.0-10.0 сая төгрөг хүртэл зээл олгосон боловч ажилгүйдлийн түвшин 7.0 хувьтай байгаа нь хүрэх үр дүнд хүрээгүй байна.

3.78. “Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 2 байна.

Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцооны 4 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.79. “Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 3, үр дүн хангагдаагүй 1 байна.

⁸⁵ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.

⁸⁶ Дэлхийн банкнаас эрхлэх гаргадаг “Бизнес эрхлэлтийн үзүүлэлт”-ийг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд тусгасан

⁸⁷ ядуурлын шугам, хэрэглээ, хувь хүн ерөнхий олонлогт байгаа нийт хүн амын тоо ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүний тооны харьцаагаар (томьёогоор) бодож гаргадаг байна.

⁸⁸ “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр” “Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ” “Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ” “Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт” “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

3.80. “Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдсан 2, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 2020 онд 14 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2-оор буурч зорилтот хүрэх түвшнээс 1-ээр буурсан нь үр дүнг хангагдсан байна.

3.81. “Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 2, үр дүн хангагдсан 1, үр дүн хангагдаагүй 1 байна.

Дүрслэл 35

- Халдварт бус өвчнөөс үүдсэн нас баралтыг бууруулах зорилтын хүрээнд зүрх судасны өвчний шалтгаантай нас баралтыг 2020 онд 17.4 хувьд хүргэж бууруулах зорилт тавьж 16.4 хувьд хүргэж бууруулснаар үр дүн хангагдсан байна.



Эх сурвалж: “Эрүүл мэндийн үзүүлэлт – 2020” Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ

Дүрслэл 36

- Хорт хавдраар нас баралтын дүн 2020 онд 13.2 хувьтай гарсан нь зорилтот түвшингөөс 2.7 хувиар их байна.



Эх сурвалж: “Эрүүл мэндийн үзүүлэлт – 2020” Эрүүл мэндийн хөгжлийн төв ДЭМБ

3.82. “Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдсан 2, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Дархлаажуулалтын түвшинг I үе шатанд 98.5 хувьд хүргэхээс 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд В, С вирусн эрт илрүүлэг, шинжилгээнд хамруулах, элэгний С вирусн эсрэг эмийг хөнгөлөлттэй үнээр олгосон зэргээс 10 000 хүн амд вирус гепатитын өвчлөл 0.8 ногдож байгаа нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 55 тохиолдлоор буурч хүрэх үр дүнг хангасан байна.
- Сүрьеэгийн тархалтыг 2020 онд 14.4 хувь хүртэл бууруулахаар төлөвлөж, Ерөнхийлөгчийн ивээл дор ЕБС-уудаар сүрьеэгийн оношилгооны ажил зохион байгуулж⁸⁹ 2019 оны жилийн эцсийн байдлаар 10 000 хүн амд сүрьеэгийн тохиолдол 14.2 хувь хүрч, уг зорилтын хүрэх түвшин хангагдсан байна.

Мэдлэгт суурилсан нийгэм ба үр чадвар бүхий Монгол хүний 5 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.83. “Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ” зорилтын хүрээнд үр дүн хангагдаагүй 2 байна.

⁸⁹ Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан сүрьеэ өвчнийг устгах үндэсний чуулган, ЕБС-ийн сурагчдын дунд тандалт явуулах, сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэгийг 50% хүртэл нэмэгдүүлэх зорилготой

- СӨБ-ыг нийт хүүхдийн хамран сургалтын бохир жинг I үе шатанд 70.0 хувь байхаар хүрэх түвшнийг тодорхойлсон боловч 2020 онд 84.4 хувь буюу зорилтот хувиас 14.4 хувь илүү байж зорилт хангагдаагүй байна. Хүүхэд бүрийг стандарт шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах зорилт тавьж, СӨБ-ийн анги дүүргэлтийг 2020 онд 20 ортой байхаар зорилт тавьсан боловч энэ зорилт хэрэгжээгүй буюу 2016-2020 онд анги дүүргэлтийн тоо 31.7-32.4 болж өссөн байна.

3.84. “Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна” зорилтын хүрээнд үр дүн тодорхойгүй 3, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Боловсролын чанарыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор “Боловсролын олон улсын чанарын үнэлгээ⁹⁰ /PISA/-д хамрагдах гэрээнд 2018 онд гарын үсэг зурж, 2019 оноос үнэлгээ хийлгэх бэлтгэл ажлыг хангаж, 2020 оноос үнэлүүлэх байсан ч 2020-2021 оны хичээлийн жилд танхимын сургалт бүрэн зогссон нь хүрэх үр дүнг хангахгүй байх шалтгаан болжээ.

3.85. “Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр үр чадвар эзэмшүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 2, үр дүн хангагдаагүй 1 байна.

- Германы олон улсын хамтын ажиллагаа, АХБ-ны санхүүжилтээр “Хөдөлмөрийн үр чадвар олгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд 1025 багш, 16 салбарын 200 гаруй мэргэжлээр төрийн болон хувийн өмчийн 80 гаруй МСҮТ-д нийт 50.8 мянган суралцагч хамрагдсан ч 60.0 мянгад хүргэх үр дүн хангагдаагүй байна.

3.86. “Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 2 байна.

- БСШУЯ-аас “Судалгааны их сургууль-үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж Засгийн газарт хүргүүлсэн, Дээд боловсролын чанарыг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх хүрээнд АХБ-ны санхүүжилтээр “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”⁹¹ 2017-2018 онд хэрэгжиж АШУУИС, МУИС, МУБИС, ШУТИС, ХААИС-ийн 7 хөтөлбөр /АШУУИС-ийн Хүний их эмч, МУИС-ийн Мэдээллийн технологи, МУБИС-ийн Математик, ШУТИС-ийн Цахилгаан холбоо, Геодези, ХААИС-ийн Механик инженер/-т 2020 оны байдлаар магадлан итгэмжлэл олгоогүй байна.

3.87. “Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгэм ба үр чадвар бүхий Монгол хүнийг хөгжүүлнэ” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 1, үр дүн хангагдаагүй 1 зорилт байна.

- МУЗГ-ын 2017 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-д шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээний чиглэлээр Засгийн газраас үзүүлэх санхүүжилтийн дэмжлэг 2020 он гэхэд ДНБ-ий 2.0 хувьд хүргэж өсгөхөөр зорьсон боловч ДНБ-ий 0.17 хувьтай буюу хүрэх түвшин хангагдаагүй байна. Зорилт хэрэгжээгүй гол шалтгаан нь холбогдох хууль, эрх зүйн шинэчлэлт, нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байсан нь нөлөөлсөн байна.

Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилгын I үе шатны 6 зорилтын 14 хүрэх түвшингээс үр дүн хангагдсан 1, үр дүн хангагдаагүй 10, хүрэх үр дүн тодорхойгүй 3 байна

Усны нөөцийн нэгдсэн менежментийн 2 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.88. “Усны нөөцийг хамгаалж, хомстлоос сэргийлнэ.” зорилтын хүрээнд үр дүн хангагдсан 1, үр дүн хангагдаагүй 2 байна. Тухайлбал:

⁹⁰ Сургалт судалгааны ажлыг зохион байгуулгч тал Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /OECD/, АНУ-ын боловсролын тестийн төв /ETS/

⁹¹ АХБ-ны санхүүжилтээр 497,857 ам доллар зарцуулсан

- Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, Ус үндэсний хөтөлбөрийн хүрээнд гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.9 хувь нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаад байна.
- Хур тунадас, гадаргын ус хуримтлуулах зориулалттай 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах хүрээнд Монгол оронд гадаргын усны хуримтлал бий болгох, урсцын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх “Хөх морь” төслийн⁹² судалгааны ажил хийгдэж байгаа ч үр дүн хангагдаагүй.
- 2018-2019 онд гидрогеологийн дунд масштаб (1:200,000)-ын зураглалын ажлыг⁹³ хийж, 2019 оны жилийн эцсийн байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 14.6 хувьд хүрч зорилтот үр дүнг 0.4 хувиар хангаагүй байна.

3.89. “Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 2 байна. Тухайлбал:

- 2016-2020 онд баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлээр Өвөрхангай, Дундговь, Баян-Өлгий, Дархан-Уул аймаг, Майдар хотын хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул, судалгааны ажлуудыг улсын төсөв, гадаад зээл тусламжийн хөрөнгөөр⁹⁴ хийж гүйцэтгэснээр баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 75-д хүрсэн ч үр дүн 0.5 хувиар бага байна.
- 2018 оны байдлаар нийт хүн амын 37.3 хувь, Улаанбаатар хотын хүн амын 36.8 хувь нь ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбогдон сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон байна. 2017-2020 онд Японы Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр АХБ, БОАЖЯ хамтран “Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлснээр 900 эко ариун цэврийн байгууламж (экосан)-ийг суурилуулан гарсан өтгөнийг боловсруулах “Бордооны цэг байгуулах” ажлыг эхлүүлсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 2 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.90. “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшигийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн тодорхойгүй 2 байна. Тухайлбал:

- 2019 онд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” төслийг эхлүүлсэн ч хүрэх үр дүн тодорхойгүй;
- ОБЕГ-аас ОУ-ын байгууллагын дэмжлэгтэйгээр байгалийн гамшигт үзэгдэл, эрсдэлийг бууруулах, даван туулах чадварыг эзэмшүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх арга хэмжээг зохион байгуулсан ч хүрэх үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

3.91. “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 2 байна.

- Эрчим хүчний салбарт нийт эрчим хүчний үйлдвэрлэлээс ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг /СЭХ-ний эзлэх хувийг 20 хувьд хүргэн/ ашиглан бууруулахаар төлөвлөн эрх зүйн баримт бичгийг⁹⁵ боловсронгуй болгохын зэрэгцээ гадаадын зээл тусламж⁹⁶, хувийн хөрөнгө оруулалтаар⁹⁷ төсөл, арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2020 оны байдлаар нийт эрчим хүчний

⁹² “Хөх морь” төсөлд “Орхон говь”, “Хэрлэн говь”, “Онги говь” зэрэг төслүүд хамрагдаж, Байгаль орчин, уур амьсгалын сангийн “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төсөл”-өөс дэмжлэг үзүүлэхээр 60.0 сая төгрөг зарцуулсан байна.

⁹³ Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” (“МИНИС” төсөл), Австралийн Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хийгдсэн.

⁹⁴ БОАЖС-ын багцад хайгуул, судалгааны ажилд улсын төсвөөс 2016 онд Өвөрхангай аймгийн Гучин-Ус сум 110.0 сая.төг, 2017 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сум 186.0 сая.төг, 2018 онд Баян-Өлгий аймгийн төв болон Ховд аймгийн Дөргөн сум 198.0 сая.төг, 2019 онд Дархан-Уул аймгийн Шарын гол 119.0 сая.төг, Дорноговь аймгийн Сайншанд, Хатанбулаг сумдын төв, Говь-Алтай аймгийн Цогт сумын төвийн усны хайгуулыг Дэлхийн банкны “Уул уурхайн хөрөнгө оруулалтын дэд бүтцийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр, 2020 онд Засгийн газрын нөөц хөрөнгөөс Майдар хотын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуулд 650,0 сая.төг зарцуулсан байна.

⁹⁵ “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)”, “Эрчим хүчний аудит хийх журам”, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд СЭХ нийлүүлэх үнийг бууруулах төсөл, хөтөлбөрийг олон улсын жишгийн дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар хэрэгжүүлэхээр нэмэлт, өөрчлөлт оруулсан, улмаар 21 аймагт эрчим хүч хэмнэлтийн дэд хөтөлбөр батлагдсан зэрэг.

⁹⁶ Японы Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Баруун бүсэд СЭХ-ийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Ховд аймгийн Мянгад, Завхан аймгийн Улиастай, Хөвсгөл аймгийн Мөрөн, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Алтай сумдад 10 МВт нарны цахилгаан станц, Увсын Өмнөговь, Завхан аймгийн Тэлмэн сумдад 5 МВт салхин цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулсан

⁹⁷ Клинт эрчим ХХК 50 МВт Клинт эрчим ази ХХК 50 МВт, Сайншанд Салхин парк 55 МВт зэрэг салхин цахилгаан станц, Нарантээг ХХК 15 МВт, И Эс би Солор ХХК 10 МВт, Дезерт Солар Пауэр Вуан ХХК 30 МВт зэрэг нарны цахилгаан станц байна

суурилагдсан хүчин чадалд СЭХ-ний эзлэх хэмжээ 18 хувьтай, нийт үйлдвэрлэлд 10 орчим хувьтай болж, СЭХ үйлдвэрлэлээр нүүрстөрөгчийн хийн /CO₂/ ялгаруулалтыг 650.0 мянган тонноор бууруулсан нь өнөөгийн тооцооллоор авч үзэхэд 2 хувиар бууруулсан байна.

- Харин Монгол Улс Парисын хэлэлцээрт⁹⁸ нэгдэн орж хүлэмжийн хийн ялгарлыг⁹⁹ бууруулахад салбар бүр өөрсдийн хувь нэмрийн тодорхой бодлогын зорилтуудыг дэвшүүлэн хууль, эрх зүйд нэмэлт өөрчлөлт оруулах, стандарт норм, бодлогын баримт бичгийг батлах зэргээр эрх зүйн орчныг бий болгон бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн зэрэг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч нүүрстөрөгчийн хийн ялгарлыг хэрхэн нэгдсэн байдлаар тооцож дүгнэх арга, аргачлал байхгүй, хүлэмжийн хийн тооллого хийгээгүйгээс зорилтот түвшинг хангасан эсэх нь тодорхойгүй байна
- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14000 багц олон улсын стандартыг Монгол Улсын үндэсний стандартаар нэвтрүүлэх ажлыг 2016-2019 оны хооронд зохион байгуулж 15 стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, уг стандартыг 12 аж ахуй нэгж хэрэгжүүлж байна.

Экосистемийн тэнцвэрт байдлын 2 зорилтын I үе шатны хүрэх үр дүн:

3.92. “Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 2 байна.

- УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор 22 дархан цаазат газрын 3.4 сая га талбай, 2020 оны 46 дугаар тогтоолоор цэнгэг усны нөөц томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авахаар хилийн заагт өөрчлөлт оруулснаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 21.0 хувь болсон байна.
- 2016-2020 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр экологийн ач холбогдол бүхий 14.5 мянган га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлт, ойн цэвэрлэгээг хийж, цөлжилтөөс хамгаалах ойн зурвасыг 460 га талбайд байгуулж, ойг хөнөөлт хортон шавьж, өвчний судалгааг 1.3 сая га талбайд, хортон шавьжийг устгах тэмцлийн ажлыг 20.0 мянган га талбайд хийж, томоохон суурин газрын ногоон бүсийг ойжуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр ойгоор бүрхэгдсэн талбай нийт газар нутгийн 7.96 хувьд хүрсэн байна.

3.93. “Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна” зорилтын хүрээнд хүрэх үр дүн хангагдаагүй 2, хүрэх үр дүнг тодорхойгүй 1 байна.

- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд зорилтын хүрээнд БХБЯ-аас 2016-2020 онд Улаанбаатар хот, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Архангай, Дорнод, Ховд, Говь-Алтай, Сүхбаатар, Сэлэнгэ зэрэг аймгийн төвүүдийн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ногоон байгууламжийн эзлэх хувийг 15-20 хувьд хүргэхээр тусган баталсан ч хэрэгжилтийг хянаж дүгнээгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.
- Улсын хэмжээнд 2018 оны байдлаар зөвшөөрөгдсөн 390 хог хаягдлын төвлөрсөн цэгт нийт 3,4 сая/тонн хог хаягдал тээвэрлэн зайлуулдаг¹⁰⁰ дахин боловсруулах боломжтой 1.5 сая тонн хог хаягдал байдаг байна. Улаанбаатар хотод хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэх төслийг¹⁰¹ хэрэгжүүлснээр 2018 онд 7.7 мянга, 2019 онд 16.9 мянга, 2020 оны хагас жилийн байдлаар 10.2 мянган тонн хог хаягдлыг дахин боловсруулалтад оруулсан байна. Дээрх 3 төвлөрсөн хогийн цэгт бүртгэгдэж, дарж булж байгаа хог хаягдлын хэмжээ 2019 онтой харьцуулахад 26.9 мянган тонн буюу 31.4 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд нийт хог хаягдлын хэдэн хувийг дахин боловсруулж байгаа тоо мэдээлэл байхгүй байна.

⁹⁸ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (НҮБ/УАӨСК)-ын Парисын Хэлэлцээрийг 2016 оны 09 дүгээр сарын 01-нд соёрхон баталж, “Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт” бичиг баримтыг 2019 оны 11 дүгээр сард Засгийн газар 407 дугаар тогтоолоор баталсан байна.

⁹⁹ 2017 оны тооллогоор Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд 0.1% эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байна. Нийт хүлэмжийн хийн ялгарлын 50.1 % эрчим хүч, 48.5 % ХАА, 0.95 % аж үйлдвэр, 0.5% хог хаягдлын салбараас ялгардаг бөгөөд хүлэмжийн хийн бүтцээр нь авч үзвэл 46.4% нүүрсхүчлийн хий (CO₂), 32.9%-г метан хий (CH₄), 20.4%-г азотлог исэл (N₂O), 0.3%-ийг гидрофторт нүүрстөрөгч (HFC) тус тус эзэлдэг байна.

¹⁰⁰ Хог хаягдлыг төрлөөр нь авч үзвэл нийт зайлуулсан хог хаягдлын 91.8%-ийг ахуйн, 8.2% нь үйлдвэрийн хог хаягдал эзэлж байна. Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын тогтоол 4, БОАЖС, Сангийн сайдын хамтарсан 3, БОАЖС-ын 8 тушаалаар дүрэм, журам батлан мөрдөж байна.

¹⁰¹ Улаанбаатар хотод хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд эх үүсвэр дээр нь ангилан ялгах мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээн нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, улмаар ТББ-тай хамтран нийслэлийн Морингийн даваа, Цагаандаваа, Нарангийн энгэрийн 3 төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг хянаж, хог хаягдлыг төрөлжүүлэн, мэдээллийг нэгтгэн боловсруулж, өдөрт 300 тонн хог хаягдлыг дахин боловсруулах хүчин чадалтай, 10.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хог ангилан ялгах бүрэн автомат үйлдвэрийг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт 2019 оноос эхлэн барьж, 2020 онд ашиглалтад оруулсан байна.

Дүрслэл 37

- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас “Таван толгой түлш” ХХК-ийг байгуулан нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлыг хийж байгаа ч агаарын бохирдол төдийлөн буураагүй байна.



Эх сурвалж: ҮСХ

Тогтвортой хөгжлийн засаглалын зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлоогүйгээс бодлогын зорилт 2020 онд хүрэх үр дүнг хангасан эсэхийг хянах боломжгүй байна

3.94. “Тогтвортой хөгжлийн засаглал”-ын зорилтыг эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтуудтай харьцуулахад хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлоогүйгээс бодлогын зорилт 2020 онд хүрэх үр дүнг хангасан эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Засаглалын 4 зорилтын I үе шат (2016-2020)-ны хүрэх үр дүн:

3.95. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.” зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан бөгөөд уг хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

3.96. “Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.” зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг 2018 онд баталсан бөгөөд Төрийн бус байгууллагын тухай, Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай багц хуулийн төсөл боловсруулсан байна.

3.97. “Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.” зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Дүрслэл 38

- Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2¹⁰²-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталсан. Төрийн улс төрийн албан тушаалтны хувьд УИХ-ын 2009 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж байгаа бол



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл

¹⁰² 40.2.Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

бусад улс төрийн албан тушаалтнуудын хувьд мөрдөх ёс зүйн дүрэм батлагдаагүй байна.

- Төрийн албаны зөвлөлөөс гаргасан ёс зүйн зөрчлийн мэдээллээс үзэхэд 2020 онд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил 2014 оны үзүүлэлттэй харьцуулахад төдийлөн буураагүй байна.
- УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 11 зорилт, 83 үйл ажиллагаа, 216 арга хэмжээг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгааснаас 205 арга хэмжээг хөтөлбөрийн эхний үе шат буюу 2017-2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хөтөлбөрийн I үе шатанд хэрэгжүүлэх 205 арга хэмжээний хэрэгжилт 2019 онд дунджаар 59%-тай байсан ба 42 арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн, 84 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 66 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 13 арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.
- Авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 2020 онд 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оноос 5 байр ухарсан үзүүлэлт болсон байна. Монгол Улсын 2020 оны авлигын индексийн оноог Ази Номхон далайн бүсийн дундаж оноо (45 оноо)-той харьцуулахад 10 оноогоор бага, бүс нутгийн хэмжээнд ихээхэн бууралт үзүүлсэн, авлигын эсрэг бага хүчин чармайлт гаргасан орны тоонд орсон байна. Энэхүү үзүүлэлтээс дүгнэхэд бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгах зорилгын хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө хангалтгүй байна.

“Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индекс¹⁰³-ийн үзүүлэлт дараах байдалтай байна.

Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс							Хүснэгт 19.
	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Монгол Улсын дундаж оноо	39	39	38	36	37	35	35
Эзэлсэн байр	80	72	87	103	93	106	111

Эх сурвалж: <https://www.transparency.org/en/cpi/>

3.98. “Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно” зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- МУЕС-ын 2018 оны 165 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн тайлангийн төслийг боловсруулж АНУ-ын Нью-Йорк хотноо 2019 онд зохион байгуулагдсан Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэлийг танилцуулах 51 орны тоонд багтсан байна. Энэхүү илтгэл нь ТХЗ-ыг улс орныхоо онцлогт нийцүүлэн нутагшуулж буй үйл явцыг дүгнэж, хөгжлийн асуудлаар нийгмийн зөвшилцлийг бий болгох, асуудлыг олон талаас нь хэлэлцэх, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагаа, хандлагыг бэхжүүлэх үр нөлөөтэй байна.

3.99. Урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх явцад давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр тооцоолоогүй эрсдэл бий болох үед нарийвчилсан зохицуулалт хийх бодлогын¹⁰⁴ арга хэмжээ авч байгаа ч тухайн жилийн зорилтот түвшин, үр дүн бүрэн хангагдаагүй байна.

МУТХУБ-2030-ын баримт бичгийн I үе шатны зорилт, арга хэмжээний зардал, үр ашиг, үр нөлөөг тооцоогүй, санхүүжилтийг тайлагнаагүй байна

3.100. Төрийн захиргааны төв байгууллагууд ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5¹⁰⁵-д заасны дагуу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2016-2017 он болон 2018 оны эхний хагас жилийн явцын хэрэгжилтийн тайланг бэлтгэн, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд Сангийн яам тайланг нэгтгэн боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

¹⁰³ Авлигын төсөөллийн индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш бөгөөд дэлхийн 180 гаруй орныг хамруулан АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Хонгконг улсад байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээний авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалаар индексийг тооцон 0-100 онооны хооронд тодорхойлдог ба 0 оноо нь өндөр авлигатай, 100 оноо нь авлига үгүй илэрхийлдэг үзүүлэлт юм.

¹⁰⁴ УИХ-ын 2020.04.09-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээ”, УИХ-ын 2020.04.29-ний өдрийн 32 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”

¹⁰⁵ Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.101. Гэвч ЗГХЭГ-аас Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.5.1¹⁰⁶-т заасны дагуу Сангийн яамнаас ирүүлсэн тайланг хянаж, танхимын хуралдаанд хэлэлцүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

3.102. Сангийн яам ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7¹⁰⁷-д заасны дагуу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 2020 онд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй, Засгийн газраас ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.8¹⁰⁸-д заасны дагуу хөндлөнгийн үнэлгээний тайланг УИХ-д танилцуулаагүй байна.

3.103. Бодлогын баримт бичгийн явцын хэрэгжилтийг үнэлэх нь тухайн бодлогын зорилго, зорилт зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах талаар арга хэмжээ авах, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үр нөлөөтэй боловч “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” -ын I үе шатны хэрэгжилтийн явцыг үнэлээгүй байна.

Үндэсний аудитын газраас 2018 онд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаас хойш үндэсний хэмжээний зорилтын биелэлтэд ахиц, дэвшил гараагүй байна.

3.104. Үндэсний аудитын газраас 2018 онд Тогтвортой хөгжлийн зорилгын бэлэн байдалд гүйцэтгэлийн, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг тус тус хийсэн бөгөөд эдгээр аудитын хүрээнд илрүүлсэн асуудлыг “Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт” аудитаар үнэлэхэд зарим асуудлын хүрээнд ахиц дэвшил гараагүй байна.

Хүснэгт 20

ҮАГ-аас 2018 онд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаас хойш үндэсний хэмжээний зорилтын биелэлтэд гарсан өөрчлөлтийн судалгаа

Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын илрүүлэлт /2018 он/	“Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт” аудитын илрүүлэлт /2021 он/
Ахиц гарсан:	
“Тогтвортой хөгжлийн зорилго-2030” болон “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа холбоог үнэлээгүй байна.	✓ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөгжлийн бодлогын 17 зорилготой уялдуулсан эсэхэд Засгийн газраас судалгаа хийж дүгнэсэн ч судалгааны ямар арга аргачлалыг ашиглаж, үнэлсэн нь тодорхойгүй байна.
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийг хариуцан хэрэгжүүлэх бүх шатны байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлоогүй байна.	✓ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний мэдээллийн эх үүсвэр болон харцуцах байгууллагыг заасан байна.
Ахиц гараагүй:	
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийг хариуцан хэрэгжүүлэх төрийн	✗ Сангийн яам болон ҮХГ-ын хувьд макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр чиг үүргийн давхардал бүрэн арилаагүй байна.

¹⁰⁶ төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянаж танхимын хуралдаанд хэлэлцүүлнэ. Хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

¹⁰⁷ Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна

¹⁰⁸ Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулна

байгууллагууд чиг үүргийн давхардалтай байна.	
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг тодорхойлоогүй байна.	* ХБТТХ /хүчингүй болсон/-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна хэмээн заасан байна. * УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050”-д санхүүжилтийг батлаагүй байна.
Үндэсний хэмжээний хөгжлийн зорилгын зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг батлаагүй байна.	* Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг батлаагүй байна.
Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна	* Сангийн яам хуульд заасан чиг үүргийн хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын I үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулаагүй байна
Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх журмыг боловсруулаагүй байна.	* Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг үүсгэсэн ч, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийг хууль, журмын өөрчлөлтөд нийцүүлэн хөгжүүлээгүй байна.

Эх сурвалж: УАГ

3.105. Мөн УАГ-аас 2018 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлан”-д үзэл баримтлал болон энэхүү хууль батлагдсантай холбогдуулан хөгжлийн бодлогыг уялдуулах, зарим шаардлагагүй бодлогыг зогсоох, шинэчлэн боловсруулах ажил удаашралтай байна гэж дүгнэн Засгийн газарт зөвлөмж хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.

ДҮГНЭЛТ: Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилтын 47.3 хувь нь хүрэх үр дүн тодорхойгүй байсан бол, “Алсын хараа 2050”-ын зарим зорилго, зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бүрэн тодорхойлоогүй, үнэлэх боломж бүрдээгүй байна.
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэжлийн институтын бүтэц, зохион байгуулалт тогтворгүй, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, босоо болон хэвтээ тогтолцооны уялдаа сул, нэгдсэн тогтолцоо төлөвшөөгүй байна.
3. “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зарим зорилт шалгуур үзүүлэлтгүй, тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой байх шинжийг хангаагүй нь зорилт хэрэгжихгүй байх, үр дүнг үнэлэх, үр нөлөөг тооцох боломжгүй болох эрсдэлтэй байна.
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, шинэчлэх, хянах, удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэгдсэн сан бүрдээгүй, системийг хөгжүүлж, шинэчлэх ажил удаашралтай, үр нөлөө хангалтгүй байна.
5. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтэд суурилсан **“Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт”** батлагдаагүй байгаа нь Монгол Улс дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгыг 2030 онд үнэлүүлэхэд бэлэн бус байна.
6. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн 44 зорилтын I үе (2016-2020) шатны 127 хүрэх түвшингээс 10.2 хувь нь үр дүн хангагдсан, 42.5 хувь нь үр дүн хангагдаагүй, 47.3 хувь хүрэх үр дүн тодорхойгүй байгаа нь бодлогын хэрэгжилт, ахиц дэвшлийг тодорхойлж, үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.
7. Засгийн газар “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын I үе шат (2016-2020)-ны зорилтын үр дүн, үр ашиг, санхүүжилтийг нэгтгэж тайлагнаагүй, зорилтын үр нөлөөг үнэлэхгүйгээр “Алсын хараа 2050”-ыг хэрэгжүүлж эхэлсэн байна.
8. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтворгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1.7-д **“...Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна...”** гэж заасантай нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ: Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлсэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн зарим байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог төлөвшүүлэх;
2. Хөгжлийн бодлого төлөвлөж, боловсруулах бүх түвшний оролцогч, иргэд, олон нийтийг иж бүрэн, цогц мэдээллээр хангах, мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлтийг технологийн дэвшил ашиглан эрчимжүүлж, системийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;
3. “Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулан түүнд нийцүүлэн “Алсын Хараа-2050” бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд хөгжлийн бодлогын зорилго, зорилтын хүрсэн үр дүн, түүний санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг тайлагнаж, үр нөлөөг үнэлэх, сайжруулах;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүрэг бүхий байгууллагуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх ажлын уялдаа холбоог хангах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Засгийн газраас баталсан холбогдох журмыг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин, санхүүжилттэй нь уялдуулан үр дүн, үр нөлөөг бодитой хянаж үнэлэн, холбогдох байгууллагад үнэн зөв тайлагнах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ:



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 12 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар ХТ/ЗМ

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ЗАНДАНБАТ ТАНАА

Санал, мэдээлэл хүргүүлэх тухай

Танай 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/2670 тоот “Тайлангийн төсөлд санал авах тухай” албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь санал, мэдээллийг хүргүүлж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2015 онд баталснаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

Хуулийг хэрэгжүүлэх явцад үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ чиглэлийн мэргэшсэн байгууллагын статус, чиг үүргийг тодорхой тогтоох, чиг үүрэг хоорондын уялдааг хангах, хөгжлийн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд тулгуурлан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого тогтвортой, залгамж чанартай, нэгдсэн, цогц, уялдаатай байх зарчим, шаардлагыг хангасан байх тогтолцоонд шилжиж байна. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газраас батлагдан гарсан 567 салангид бодлогын баримт бичгүүдийн нэгтгэл болж, Монголын түүх, үндэсний онцлог, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын дэвшилтэт үзэл баримтлалтай хослуулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Засгийн газар боловсруулж, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж, батлуулсан.

000021517404

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн зохицуулалтын хүрээнд батлагдсан ба тус бодлогын баримт бичигт үндэслэн дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын тухай (2020 оны нэмэлт, өөрчлөлт) хуульд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг тусгаж өгснөөр төрийн захиргааны төв байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад чухал ач холбогдолтой болсон. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2021 он) хууль батлагдсанаар Эдийн засаг, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулах болж, шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Шинээр байгуулах эдийн засаг, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтвортой байдлыг хангаснаар институцийн чиг үүргийн хуваарилалт, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тодорхойлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, байгууллагын чадавх, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Ингэснээр хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой, оновчтой, үр дүнтэй, харилцан уялдаатай нэгдмэл, цогц байх, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулах, үр дүнг бодитоор үнэлэх, дүгнэх, үнэн зөв тайлагнах суурь нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Танай байгууллагаас ирүүлсэн Аудитын тайлангийн төсөлд дурдсан асуудлуудын саналаа холбогдох тайлбар, мэдээллийн хамт хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

№	Үзүүлэлт	Ирүүлсэн санал,тайлбар
1	Тайлбар 1-ийг үзнэ үү.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд 52 хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн нь Улсын Их Хурлын намрын чуулганы хуралдаанаар хэлэлцэгдэж, батлагдсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуулиудын нэмэлт, өөрчлөлт эцэслэн батлагдсанаар эдгээр хууль хоорондын уялдаа хангагдаж, давхардал хийдэл, зөрчилгүй болсон. Эдгээр хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийн “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “энэ хуулийн 28.6-д заасны дагуу” гэснийг “хууль тогтоомжид нийцүүлэн” гэж тус тус өөрчлөгдөн батлагдсан. Мөн Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтын “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “урт хугацаанд” гэснийг тус тус хасч, Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.2 дахь заалт, 12¹ дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.3.6, 28.3.7 дахь заалт, 28.8, 28.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсон болно.
2	Тайлбар 2-ыг үзнэ үү.	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэгдэж, эцэслэн батлагдсан. Тус хуулийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.5-д зааснаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах үүрэгтэй” болохыг хуульчилсан. Иймд ЗГХЭГ-аар дамжуулахгүйгээр төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл судалгаа авч, хамтран ажиллах боломжтой байдаг.
3	Тайлбар 3-ыг үзнэ үү.	Энэ чиглэлээр ажиллаж буй төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулахдаа мэргэжлийн тусгай шаардлагыг тусгаж, түүнийхээ дагуу сонгон шалгаруулан томилдог. Төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академиас төрийн захиргааны албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт болон холбогдох бусад сургалтын агуулгад хөгжлийн бодлого, төлөвлөлт, стратегийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлийн агуулгыг тусгадаг. МУИС-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр магистрийн хөтөлбөр батлагдсан ба 2022 оны 1 дүгээр сараас эхлэн элсэлт авч эхлэхээр болсон.

4	Тайлбар 4-ийг үзнэ үү.	“Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин шалгуур үзүүлэлтийг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг батлуулж, тус тогтоолын төслийг боловсруулан дуусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. “ТХЗ-2030”-ын зорилго, зорилт нь “Алсын хараа-2050” болон холбогдох бусад бодлогын баримт баримт бичгүүд дэх бодлогын зорилго, зорилттой 83 хувь нь агуулгаараа уялдаж байх тул “ТХЗ-2030”-ийн хэрэгжилтийг Монгол Улс тооцож, тайлагнах боломжтой.
5	Тайлбар 5-ыг үзнэ үү.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд баталсан УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1.2, 1.3 дахь хэсэгт Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг энэ хуульд нийцүүлэх, баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан 17 (Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоол, 2021), Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор батлагдсан 62 (Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоол, 2021) баримт бичгийг хуульд нийцүүлэх зорилгоор хүчингүй болсонд тооцсон байна. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хуульд нийцүүлэх зорилгоор “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 314 дүгээр тогтоолоор батлагдсан. (ЗГ-ын 62 тогтоолыг хүчингүй болгосонд тооцсон.) “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хурлын “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 2021 оны 89 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсан. (УИХ-ын 17 тогтоолыг хүчингүй болгосонд тооцсон.)
6	Тайлбар 6-г үзнэ үү.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго тус бүрийн хүрээнд тодорхойлсон хяналт-шинжилгээ, үнэлгээний 73 шалгуур үзүүлэлтийг баталсан. Шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг тодорхойлохдоо 2019 оны байдлаар олон улсын байгууллага, Үндэсний статистикийн хороо, төрийн захиргааны төв болон төрийн бусад байгууллагуудын албан ёсны статистик үзүүлэлтийн мэдээлэл тархаах цаглавраас шалтгаалан 2014-2019 оны үзүүлэлтүүдээс сонгосон бөгөөд хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжүүлж дуусахад хүрэхээр хүлээгдэж буй үр дүнг 2025, 2030, 2050 оноор тооцоо судалгаанд үндэслэн тооцож, хүрэх түвшинг тодорхойлсон. Ажлын хэсгээс 2030, 2040, 2050 оны хүрэх түвшинг тооцоолж УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-аас 2025, 2030 оны үр дүнгээ дүгнэсний дараа дараагийн 10 жилд хүрэх түвшинг тодорхойлох зорилгоор өөрчлөгдөн батлагдсан.
7	Тайлбар 7-г үзнэ үү.	Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 5 дугаар заалтад “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан” болохыг заасан. Улмаар “ТХЗ-2030”-ын зарим үзүүлэлтийг шинэчлэн тооцож, тус бодлогын баримт бичгийн 44 зорилт, 20 шалгуур үзүүлэлтийг “Алсын хараа-2050”-д тусгасан. Иймд “ТХЗ-2030”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа болно.

8	Тайлбар 8-ыг үзнэ үү.	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн мэдээллийг Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” 19 дүгээр тогтоолд заасны дагуу 2019 оны хагас жилийн байдлаар гарган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн ХЭГ/ЗЗ90 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн. Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 5 дугаар заалтад “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдаж “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон тул уг баримт бичигт дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй болно. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн (2015 он) 7 дугаар зүйлд “7.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. 7.7.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.” гэж заасан байдаг. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Алсын хараа- 2050” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг жил бүр тооцон гаргахаар ажиллаж байна.
---	-----------------------	--

Үндэсний аудитын газрын тайлбар:

ЗГХЭГ-аас ирүүлсэн 8 санал, тайлбарыг судлан үзэж, тайланд дурдсан асуудалд өөрчлөлт оруулаагүй болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	ХБТТУТ хуулийн нэр томъёоны тодорхойлолтод “ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ”-г тодорхойлж өгсөн боловч, Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалтад “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэсэн нэрээр тусгагдсан хэвээр байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 2	ХБТТУТ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх “Үндэсний хөгжлийн хүрээлэн” байгуулагдаагүй, холбогдох хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөх тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	Аудитын тайлангийн 1.27-1.29 дэх заалттай санал нэг байгаа тул тайланд хэвээр үлдээв.
Тайлбар 4	Ирүүлсэн тайлбар нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 5	Аудитын тайлангийн 2.16 дахь заалтад тодорхой дурдсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 6	Аудитын тайлангийн 2.24-2.26, 2.31 дэх заалтад тодорхой дурдсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 7	Аудитын тайлангийн Бүлэг 3-т тодорхой дурдсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 8	Аудитын тайлангийн 3.101-3.103 дахь заалттай санал нэг байгаа тул тайланд хэвээр үлдээв.

Хавсралт 1

МУТХҮБ-2030-ын хүрэх үр дүн тодорхойгүй зорилго, зарим зорилтын жагсаалт

№	Зорилго	Салбар болон зорилтын нэр	Хүрэх үр дүн тодорхойгүй
1	Эдийн засгийн тогтвортой хөгжил	Хөдөө аж ахуй	Мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлнэ
2			Үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгоно
3			Тахиан аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгоно
4			Тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг сааруулна
5			Лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ
6		Аялал жуулчлал	Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна
7			Олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлнэ
8			Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгоно
9		Аж үйлдвэр	Дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ
10			Хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлнэ
11			Зэс хайлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
12			Алт цэвэршүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ
13			Газрын тос боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.
14			Байгалийн хий, Занар боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.
15			Нүүрс боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.
16			Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ
17			Бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ
18		Эрдэс баялаг	Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхыг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах,
19			Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж,
20			байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж,
21			говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.
22			цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.
		Дэд бүтэц	

23			Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах,
24			“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах,
25			“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх,
26			аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймаг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх.
27			Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох,
28			Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх,
29			газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж,
30		Макро эдийн засгийн бодлого	Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож,
31			даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх.
32			Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно.
33			Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж,
34			өрийн зохистой түвшинг хангах.
35		Бизнесийн таатай орчин	Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулна
36			хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж худалдааны өртөг, зардлыг хямдруулна
37	Нийгмийн тогтвортой хөгжил	Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал	Зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж,
38			Халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх
39			Амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ
40			Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах
41		Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо	Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлнэ.
42			Оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
43			Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжиж, Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгана.
44			Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна
45			Халдварт өвчний хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлнэ.
46		Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн	Ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ
47			Ерөнхий боловсролын чанарыг баталгаажуулна

48			Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгоно
49			Төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ
50			Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлнэ
51			Насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно
52			Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж
53			Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүнийг хөгжүүлнэ
54	Байгаль орчны тогтвортой хөгжил	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх
55			Гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох
56		Экосистемийн тэнцвэрт байдал	Улаанбаатар хотыг утаагүй болгох.
57	Тогтвортой хөгжлийн засаглал	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.	хүрэх үр дүнг тусгаагүй
58		Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.	хүрэх үр дүнг тусгаагүй
59		Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.	хүрэх үр дүнг тусгаагүй
60		Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.	хүрэх үр дүнг тусгаагүй